

# АМИА ХОРЛОХ ЭРСДЭЛ БҮХИЙ ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ СЭТГЭЛ ЗҮЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

СЭТГЭЛ ЗҮЙЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

---

IV



*Энэхүү сэтгэл зүйн цогц үйлчилгээний хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк болон БНСУ-ын Цахим-Ази хөгжил түншлэлийн сангийн санхүүжилтээр Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй “Орон нутгийн оролцоонд тулгуурлан КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах нь” төслийн хүрээнд боловсруулав.*



ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЫН ЯАМ



From  
the People of Japan

*Хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн сэтгэл зүйч, мэргэжилтнүүдэд зориулан хэвлэв.*

#### **БОЛОВСРУУЛСАН:**

Д.ЦОГЗОЛМАА, Сэтгэл судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор

С.НАНДИН-ЭРДЭНЭ, Гүүд Нэйборс ОУТББ-ын Төсөл хөгжүүлэлтийн албаны мэргэжилтэн, сэтгэл зүйч

#### **ХЯНАСАН:**

А БҮРЭНЖАРГАЛ, Гүүд Нэйборс ОУТББ-ын Ахлах менежер

Г.НЯМБАЯР, Гүүд Нэйборс ОУТББ-ын Хөтөлбөр Зохицуулалтын Хэлтсийн менежер

Б.ЭРДЭНЭСУВД, Гүүд Нэйборс ОУТББ-ын Төсөл хөгжүүлэлтийн албаны ахлах мэргэжилтэн

ISBN: 978-9919-9011-2-7

*© Энэхүү сэтгэл зүйн үйлчилгээний цогц хөтөлбөр нь Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын оюуны өмч тул зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн олшруулах, нийтлэх, нэвтрүүлэх, цахим системд оруулах болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.*

## АГУУЛГА

---

### I. ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

### II. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

### III. ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ, БЭЛТГЭХ ЗҮЙЛС

Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхээс өмнө анхаарах, бэлтгэх зүйлс

Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад анхаарах, бэлтгэх зүйлс

### IV. ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТ, ЗААВАРЧИЛГАА

Хөтөлбөрт шаардагдах аргачлал, хэрэглэгдэхүүн

Нэг. Эрсдэлийн үнэлгээ хийх уулзалт

Хоёр. Мэдрэмж гадагшлуулах уулзалт

Гурав. Сэтгэл зүйн нөөцийг нэмэгдүүлэх уулзалт

Дөрөв. Цаашдын төлөвлөгөө гаргах уулзалт

### V. ТУЛГАРЧ БОЛОХ БЭРХШЭЭЛ, ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИ

### VI. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Уулзалтын тэмдэглэлийн хуудас

Хавсралт 2. Сэтгэл зүйн үнэлгээний хуудас

Хавсралт 3. Эрсдэлийн зэргийг үнэлэх хуудас

Хавсралт 4. Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрлийн хуудас

Хавсралт 5. Эцэг эх, асран хамгаалагчид мэдээлэл өгсөн тухай хуудас

Хавсралт 6. Эцэг эх, асран хамгаалагчид өгөх зөвлөмж

Хавсралт 7. Өсвөр насны хүүхэдтэй ярилцах загвар

Хавсралт 8. Цаашдын төлөвлөгөө гаргах хуудас, загвар

Хавсралт 9. Хөтөлбөрийг дагалдах хэрэглэгдэхүүний танилцуулга

### VII. НОМ ЗҮЙ

## ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

4

Түр хамгаалах байраар үйлчлүүлж буй өсвөр насны хүүхдүүдийн онцлог нь гэр бүлийн асуудалд суурилсан олон янзын сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай нүүр тулсан байдаг. Эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар арга зам олохгүй, тусалж дэмжих хүнгүй зэргээс шалтгаалж хүүхэд асуудлаа шийдвэрлэх нэг аргыг амиа хорлох гэж үзэн амиа хорлох бодолд автах, амиа хорлох оролдлого хийх зэргээр асуудлаа шийдвэрлэхийг оролддог.

Энэхүү сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрийг түр хамгаалан, байрлуулах үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байрны сэтгэл зүйчдийн ажлын онцлог нөхцөлд тохируулан өсвөр насны хүүхдэд амиа хорлох эрсдэлийг бууруулахад чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээнд зориулж боловсруулав.

### ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИУЛАЛТ, ҮЕ ШАТ

Зөвлөгөөний хөтөлбөрийн зорилго нь түр хамгаалах байранд байрлаж буй, амиа хорлох бодол санаа, эрсдэл бүхий өсвөр насны үйлчлүүлэгчид анхан шатны тусламж үзүүлэхэд чиглэнэ.



#### ХЭНД ЗОРИУЛАГДСАН:

Амиа хорлох эрсдэл бүхий өсвөр насны хүүхдэд



#### ХААНА ХЭРЭГЖИХ:

НЦҮТ, Түр хамгаалах байр



#### УУЛЗАЛТЫН ТОО, ҮЕ ШАТ:

4 удаагийн уулзалт, зөвлөгөө



#### НЭГ УДААГИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, УУЛЗАЛТЫН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:

1 цаг (60 хүртэл минут)



#### ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ НИЙТ ХУГАЦАА:

10-28 хоног



#### УУЛЗАЛТ БУЮУ ҮЕ ШАТ ХООРОНДЫН ХУГАЦАА:

Хамгийн багадаа 1-3 хоног,  
хамгийн уртдаа 7 хоног



#### АШИГЛАХ МАТЕРИАЛ:

Зөвлөгөөний хөтөлбөр, түүний хавсралт болон дагалдах багц хэрэглэгдэхүүн



## ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

6

Амиа хорлох гэдэг нь хэн нэгэн санаатайгаар өөрийн амийг таслах төрх үйл юм. Олон улсын эмнэлгийн нэр томъёогоор зориуд бүр мөсөн амиа хорлох үйлдлийг “суицид”, амиа хорлох оролдлого хийх тохиолдлыг “парасуицид” гэж нэрлэдэг. ДЭМБ-ын тогтоосноор тухайн оронд амиа хорлогсдын тоо 100,000 тутамд 10-аас бага байх нь доогуур үзүүлэлт, 20-оос дээш байх нь өндөр үзүүлэлт, 25-аас дээш байх нь хэт өндөр үзүүлэлт байдаг ба 2018 оны байдлаар дэлхийн дундаж төвшин 100,000 хүн тутамд 10.5 байсан. ДЭМБ-аас 15-29 насныхны дунд хийсэн судалгаагаар тэдний нас баралтын 2 дахь том шалтгаан нь “амиа егүүтгэх” гэсэн дүн гарчээ.

Прокурорын байгууллагаас “Монгол Улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдол”-ын шалтгаан нөхцөл, түүнд нийгэм эдийн засаг, гэр бүл, сургуулийн орчны нөлөөллийг 2012-2016 оны байдлаар судалсан. Судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийг эцэг, эх нь үл хайхрах, сургуулийн орчинд ялгавартай харьцах, дээрэлхэх зэрэг үйлдлүүд нь тэдний амиа хорлох хамгийн том шалтгаан болж байна. Монгол Улсад өсвөр насныхны амиа хорлолтын төвшин Зүүн Ази, Номхон далайн бүсийн дундаж төвшнөөс тав дахин их байна. 2019 онд нас барсан 20-24 насны залуучуудын 24.2 хувь нь буюу 4 хүн тутмын 1, 15-19 насныхны 23.5 хувь буюу мөн 4 хүн тутмын 1, 25-29 насны залуучуудын 19.1 хувь буюу 5 хүн тутмын нэг нь амиа хорлон нас барсан байна<sup>1</sup>.

Амиа хорлох гэдэг нь нэг удаагийн үйлдэл бус тодорхой үе шат бүхий үйл явц байдаг.

### АМИА ХОРЛОХ ҮЙЛ ЯВЦ



**1** Үхэл ба амьдралын утга учиртай холбоотой асуудлууд үүснэ. Амиа хорлохоос өмнө ихэнх тохиолдолд дасан зохицох чадвар буурдаг. Тухайлбал, сурлага муудах, юу ч сонирхохгүй байх, харилцаанаас зайлсхийх, сэтгэл хөдлөл тогтворгүй байх гэх мэт. Энэ үед амиа хорлох бодол төрдөг бөгөөд энэ нь “Би ийм амьдралаас залхаж байна”, “Би унтаад сэрэхгүй ч болоосой” зэрэг үг яриа илэрч эхэлнэ. Энэ нь амиа хорлох тухай идэвхгүй бодол юм.



**2** Амиа хорлох бодол идэвхтэй төрж тогтонгишиж эхлэх бөгөөд энэ шатанд судалж, төлөвлөгөө боловсруулж эхэлдэг. Амиа хорлох арга, цаг хугацаа, газар зэргээ сонгодог. Өсвөр насныхан өөрсдийн зорилгын талаар найз нөхөд, гэр бүлийнхэн зэрэгтээ мэдэгдэж эхэлнэ.



**3** Амиа хорлох оролдлого хийх үе. Амиа хорлох бодол төрж эхлэхээс түүнийг хэрэгжүүлэх оролдлого хүртэлх хугацааг амиа хорлолт гэж нэрлэдэг. Энэ нь хэдэн минутаас (гэнэтийн амиа хорлолт) хэдэн сар (удаан төлөвлөсөн амиа хорлолт) хүртэл үргэлжилж болно. Амиа хорлох оролдлого хийсний дараа хүүхэд анхааралтай хандах шаардлагатай. Гурван сарын дотор хүүхэд тайван болж, амиа хорлох тухай дахин ярихгүй, оролдлого хийгээгүй бол ердийн амьдралын хэв маягт шилжсэн байх боломжтой гэж үзнэ.

1 Эрүүл мэндийн хөгжлийн төв, ДЭМБ. Эрүүл мэндийн үзүүлэлт тайлан, 2019. Хуудас 193

Амиа хорлох бодол санаа, оролдлого, үйлдэл нь сэтгэцийн эрүүл мэндийн талаас үндсэн 2 шалтгаанаар бий болно.

1. Сэтгэцийн тулгамдсан асуудал

2. Сэтгэцийн эмгэг

Сэтгэцийн тулгамдсан асуудлын улмаас амиа хорлох тухай бодол санаа төрөх нь тухайн хүнд асуудал үүсгэсэн нийгэм эдийн засгийн зэрэг бодитой шалтгаанаас гадна асуудлыг хүлээн авч буй хувь хүний онцлогоос хамаарна.

Сэтгэцийн эмгэгийн шалтгаан нь сэтгэлийн хөдөлгөөний хоёр туйлт эмгэг, шизофрени, бие хүний зан төлөвийн эмгэг зэрэг өвчний улмаас амиа хорлох тухай бодол, үйлдэл бий болно.

Өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлох тухай бодол, оролдлого, үйлдэлд хүргэсэн шалтгаан нь насанд хүрэгчдийн зүгээс авч үзэхэд тийм ч чухал биш санагдах нь элбэг. Тиймээс хайхрамжгүй, өнгөц хандах алдаа их гаргадаг. Өсвөр насны хүүхдийн амиа хорлох тухай бодоход хүргэж буй нийтлэг шалтгаан:

- Гэр бүлийн зөрчил маргаан
- Үе тэнгийн дарамт дээрэлхэл
- Интернет, тоглоомын донтолт
- Хүүхдийн сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт чанар хангалтгүй байх
- Бие хүний зарим онцлогууд
- Үхлийн тухай өнгөц төсөөлөл
- Ойр дотны найз нараас амиа хорлосон, эсвэл энэ тухай төлөвлөсөн байх

Өсвөр насны хүүхдийн биеэ авч яваа байдал, зан төрхийн өөрчлөлт, сургуулийн орчны хүрээлэл, амьдралын идэвх, найз нөхдийн харилцаанд өөрчлөлт орж байна уу гэдгийг хүүхэдтэй харилцдаг хүн бүр буюу эцэг эх, асран хамгаалагч, ангийн багш, сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагын ажилтан гэх мэт хүмүүс анхаарал хандуулж байх шаардлагатай байдаг.

Энэхүү хөтөлбөр нь амиа хорлох бодол санаа төрсөн, оролдлого хийсэн өсвөр насны хүүхэд, залуучуудад сэтгэл зүйн анхан шатны тусламж буюу сэтгэл зүйн тестийн үнэлгээний дагуу анхан болон дунд шатны эрсдэлтэй үед ашиглах боломжтой. Өсвөр насны хүүхэд болон гэр бүлийнхнийг шаардлагатай мэдээллээр ханган, хүүхдийг хэрхэн асуудлаа даван туулах, өөрийн нөөцийг ойлгож нэмэгдүүлэхэд чиглэсэн бол эцэг эхчүүдэд хүүхдээ хэрхэн ажиглах, хэрхэн дэмжиж харилцах тухай зөвлөмж бүхий агуулгатай. Харин эрсдэлийн үнэлгээ өндөр үед дараагийн шатны мэргэжлийн байгууллагад цаг алдалгүй холбон зуучлах шаардлагатай болно.

Манай улсад “Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх заавар батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 18-ны А149 тоот тушаал” батлагдсан бөгөөд сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд амиа хорлох эрсдэл дунд болон өндөр хүүхдийг энэхүү тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагад холбон зуучилж дараагийн шатны үйлчилгээнд хамруулах нь зүйтэй.

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

<b>АМИА ХОРЛОХ ҮЗЭГДЭЛ</b>	Олон улсын эмнэлгийн нэр томьёогоор зориуд санаатайгаар амиа бүрмөсөн хөнөөх үйлдэл болон амиа хорлох оролдлого хийх үйлдлийг нэгтгэсэн ойлголт <sup>2</sup> .
<b>АМИА ХОРЛОХ БОДОЛ</b>	Тухайн хүнд үхэх тухай зурсхийсэн бодлоос эхлээд өдөр бүр үхэх тухай улигт бодол төрөх хүртэл тодорхой хугацааны турш үргэлжилдэг үйл явц <sup>3</sup> .
<b>АМИА ХОРЛОХ ТӨСӨӨЛӨЛ</b>	Өөрийн амиа хорлож байгаа дүр зургийг дахин дахин толгойдоо дүрслэн зурж төсөөлөх буюу ирээдүйд өөрийгөө хэрхэн амиа хорлож үхэж байгаагаа төсөөлж харах
<b>АМИА ХОРЛОХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	Амиа хорлох төсөөллөө хэрэгжүүлэх хүчтэй дур хүсэл төрдөг бөгөөд амиа хорлох аргаа сонгож түүнийгээ хэрэгжүүлэхэд зугуухан бэлтгэх
<b>АМИА ХОРЛОХ ТӨРХ ҮЙЛ</b>	Санаатайгаар өөрийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулж буй үйлдэл
<b>АМИА ХОРЛОХ ҮЙЛ ЯВЦ</b>	Амиа хорлох бодол биеллээ олж, амиа хорлохыг завдсан үйлдэл болон санаатайгаар өөрийн амийг бүрмөсөн хөнөөх үйлдэл үйлдэгдэхийг хамруулсан үйл явц.
<b>АЛДААТАЙ ИТГЭЛ ҮНЭМШИЛ</b>	Танин мэдэхүй, зан үйлийн онолын үндсэн ойлголтын нэг. Хүний гаргаж буй зан байдлын цаад шалтгаан нь алдаатай итгэл үнэмшил буюу нөхцөл байдлыг өөрөөр, урвуулж тусгаж авсантай холбоотой гэж үзээд, алдаатай итгэл үнэмшлийг засаж залруулахад чиглэсэн сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг.
<b>АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДРЭМЖ</b>	Ямар нэг аюул, заналхийлэл мэдрээгүй, айдас мэдрэхгүй байхад төрөх дотоод хандлага. Аюулгүй байдлын мэдрэмж нь хүний өссөн орчинтой ихээхэн холбоотой бөгөөд цаашид өөртөө итгэлтэй, зоримог, эрсдэлтэй алхам хийх зэрэг хувь хүний онцлог төлөвшин тогтоход чухал үүрэг гүйцэтгэдэг байна.
<b>БУСДААС ХАМААРАЛТАЙ БАЙДАЛ</b>	Тухайн хүний үзэл бодол, итгэл үнэмшилд бусдын хандлага, байр суурь хүчтэй нөлөөтэй байх, бусдын зүгээс урамшуулал, дэмжлэг үзүүлэх хэрэгцээ их байхыг хэлнэ. Бага насанд эцэг, эх, ойр дотны хүмүүсийн нөлөөгөөр голчлон тогтодог байна.
<b>МЭДРЭМЖ</b>	Хүний гадаад болон дотоод нөхцөл байдлын талаар мэдээллийг хүлээн авах механизм <sup>4</sup> . Мэдрэмж нь гаднаа ил гарахгүй, бусдад анзаарагдахгүй байж болох харьцангуй тогтвортой дотоод хандлага юм.

- 2 Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх заавар батлах тухай. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 18-ны А149 тоот тушаал
- 3 Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх заавар батлах тухай. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 18-ны А149 тоот тушаал
- 4 Б.Батсайхан, М.Дэлгэржав. Сэтгэл судлалын бага тайлбар толь. УБ.,2013



<p><b>НОЙРГУЙДЭЛ</b></p>	<p>Нойрсох боломжтой орчин болон цаг хугацаанаас үл хамаарч нойр хүрэхгүй байх, нойрсох хугацаа богиносох, улмаар өдрийн цагаар ажлын чадамж буурах шинж бүхий бие махбодод сэргэлт авчрахгүй, чанаргүй нойр 4 долоо хоногоос дээш хугацаагаар үргэлжлэхийг нойргүйдэл гэж тодорхойлдог.</p>
<p><b>ӨӨРИЙГӨӨ ГЭМТЭЭХ ТӨРХ ҮЙЛ</b></p>	<p>Үхэхийг хүсээгүй мөртөө өөрийн бие эрхтнийг гэмтээх, өөртөө хөнөөлтэй үйл хийх байдал.</p>
<p><b>СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДАЛ</b></p>	<p>Сэтгэл санааны тухайн үеийн байдал. Түр хугацааны, хувьсан өөрчлөгдөх шинжтэй.</p>
<p><b>СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭ</b></p>	<p>Сэтгэл зүйн янз бүрийн үзэгдлийг хэмжих арга барил, хэрэглэгдэхүүн.</p>
<p><b>СЭТГЭЛ ТҮГШИЛТ</b></p>	<p>Айж, эмээснээс болж үүсэх сэтгэлийн зовнил, хямрал<sup>5</sup> гэж тодорхойлдог.</p>
<p><b>СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛ</b></p>	<p>Тухайн хүний хувьд цаашдын харилцаа хандлага, мэдрэмж, хувь хүний онцлогт нөлөө үзүүлэхүйц хэмжээний таагүй үйл явдал тохиолдсон байхыг хэлнэ. Сэтгэцийн гэмтлийн нэг онцлог нь амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлж буй таагүй үйл явдал нь зөвхөн тухайн хүнд төдийгүй тухайн хүний ойр дотны эсвэл хөндлөнгийн хэн нэгэнд тохиолдож байхыг биеэр үзэж мэдэрсэн үед авч болдог. Амьдралын үйл явдал нь хүн бүрд өөр өөр байдлаар тусах бөгөөд нэг удаа гүнзгий цочролд орох, эсвэл удаан хугацаанд үргэлжилсэн байх зэргээс хамааран ялгаатай хариу үйлдлээр илэрнэ.</p>
<p><b>ТАНИН МЭДЭХҮЙ, ЗАН ҮЙЛИЙН СЭТГЭЛ ЗАСАЛ</b></p>	<p>Хүний дурын үйлдэл танин мэдэхүйн, сэтгэлийн хөдөлгөөний түвшинд явагддаг гэж үздэг сэтгэл заслын томоохон чиглэл. Дадал зуршил, сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг өөрчлөхөд чиглэсэн бөгөөд асуудал дахин давтагдахаас сэргийлэх, асуудал үүсгээд байгаа шалтгааныг шийдвэрлэх зэрэг зорилгоор хэрэглэдэг. Засалчийн өгч буй ихэнх даалгавар, дасгалыг гэрээр хийж байх боломжтой байна.</p>

5 Б.Батсайхан, М.Дэлгэржав. Сэтгэл судлалын бага тайлбар толь. УБ.,2013

## ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТ, ЗААВАРЧИЛГАА

№	Аргачлал, хэрэглэгдэхүүний нэр	Зориулалт, тайлбар
1	Нийлэмжийн арга	Энэхүү арга нь шинжлүүлэгчид тухайн мөчид ямар нийлэмж зонхилон үүсэж байгааг илрүүлдэг. Хэрэглэхэд хялбар, богино хугацаанд шинжлүүлэгчийн талаар нарийн мэдээлэл авах боломжтой тусгалын арга юм. Судлаачаас ур чадвар шаардана. Санаандаа орсон үгнүүдийг аль болох бодолгүй, түргэн нэрлэх эсвэл бичих даалгавар өгнө.
2	Түргэвчилсэн асуулга	Амиа хорлох бодол, төлөвлөгөө, үйлдэл байгаа эсэхийг илрүүлэхэд чиглэсэн. 4 асуулттай, хэрэглэхэд хялбар. ДЭМБ-аас боловсруулсан аргачлал.
3	MAST аргачлал	Амьдрах эсвэл үхэх талаар бодлын аль нь давамгайл байгааг илрүүлэхэд чиглэнэ.
4	RES асуулга	Өөрийн үнэлэмж хэр байгааг судлахад чиглэсэн.
5	Мэдрэмжийн картууд	Зургууд сэтгэцийн үйл ажиллагааны идэвх суларсан үед, өөрийн байдлыг үгээр илэрхийлэхэд төвөгтэй үед үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлыг нээн харуулахад ихээхэн тустай байдаг. Мэргэжилтэн мэдрэмж, сэтгэл хөдлөлтэй холбоотой картуудаас сонгон ашиглаж болно. Тухайлбал, Банхар карт, Ий күү, Шүхэр карт
6	Нөөцийн картууд	Зургууд нь хүн эрч хүч авч болох олон санааг агуулсан байдгаараа эерэг сэдэл төрүүлэхэд тохиромжтой. Мэргэжилтэн өөрийн хэрэглэдэг нөөцийн картуудаас сонгон ашиглах боломжтой. Тухайлбал, Эрэгтэй хүний хүч, Эмэгтэйчүүдийн 70 нөөц, Нөөц, Нөөц бий болгох газар гэх мэт

## СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭЭС ӨМНӨ АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

### Зөвлөгөөний өрөө болон орчныг бэлтгэх:

- “ Зөвлөгөөний өрөөнд хүүхдэд аюултай, дахин амиа хорлох оролдлого хийх эд зүйлс, хэрэгсэл болох зүйлс болон сэдэл төрүүлэх зүйлс байгаа эсэхийг нягтална.
- “ Уулзалт эхлэхээс өмнө зөвлөгөөний өрөөний агаарыг сэлгэх, байгалийн гэрэл туссан байхыг бодож гэрэлтүүлэг гаргах. Хэрэв гаднаас байгалийн гэрэл тусах боломжгүй бол ширээний гэрэл зэргийг асааж болно. Өрөөнд агаар, гэрэл оруулах нь чөлөөтэй, тайван мэдрэмжийг үйлчлүүлэгчид өгөхөд тусална.
- “ Зөвлөгөөний өрөөний сандал нь үйлчлүүлэгчид тухтай мэдрэмж төрүүлэхүйц зөөлөн байвал сайн. Мөн үйлчлүүлэгч өөрийн биед тухтай байдлаар ашиглах боломжтой дэрнүүдийг бэлтгэнэ. Сандлыг байрлуулахдаа 1.5 метр орчим зайтайгаар сэтгэл зүйч үйлчлүүлэгч суухаар, сэтгэл зүйчийн суух сандал хаалган талдаа байвал зохимжтой. Мөн зөвлөгөөний өрөөний ширээг 2 сандлын голд байрлуулна. Гэхдээ сэтгэл зүйч ширээн дээр цаас тавьж тэмдэглэл хийхээс зайлсхийгээрэй. Ширээн дээр бичихийн оронд гар самбар ашиглах нь зохимжтой.
- “ Зөвлөгөөний өрөөнд хурц өнцөгтэй, урт хатуу навчтай, улаан өнгө агуулсан цэцэг байлгахаас зайлсхийгээрэй. Мөн зөвлөгөөний эхлэл үед үйлчлүүлэгчээс өрөөнд байгаа зүйлс тухгүй мэдрэмж төрүүлж байгаа эсэхийг тодруулж асуугаарай.
- “ Бусад үйлчлүүлэгч, мэргэжилтнүүд зөвлөгөөний явцад саад болох, сарниулахаас сэргийлж зөвлөгөөтэй байгааг сануулах, илэрхийлэх бичиг өлгөж болно.
- “ Ширээн дээр хуурай салфетка байрлуулах.

### Хөтөлбөрийн дагуу хэрэглэгдэхүүн болон бусад бэлтгэл:

- “ Гар самбарыг, бичгийн цаас, бал, уулзалтын тэмдэглэлийн хуудасны хамт бэлтгэх. /Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг “Хавсралт 1”-т оруулав./
- “ Хөтөлбөрийн үе шат бүр дэх бэлтгэх зүйлстэй урьдчилан танилцаж, хавсралт материалыг хэвлэж бэлтгэх, тоног төхөөрөмжийг хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгаж, шууд хэрэглэхэд саадгүй байхаар урьдчилан шалгасан байх.
- “ Үйлчлүүлэгч ярилцахыг хүсэхгүй байх тохиолдолд өөр ашиглаж болох арга техникийг бодолцож бэлтгэсэн байх.
- “ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ уулзалт бүрийг кодолж, үе шатыг дарааллын дагуу хэрэгжүүлэхэд анхаарах.
- “ Уулзалт бүрийн дагуу тэмдэглэлийг хөтлөх.

### Амиа хорлох бодол төрсөн, оролдлого хийсэн үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхэд анхаарах:

- Амиа хорлох бодол төрсөн, оролдлого хийсэн үйлчлүүлэгчид үзүүлэх аливаа үйлчилгээ нь сэтгэцийн гэмтэлд суурилсан буюу гэм хор учруулахгүй байх зарчмуудыг баримталдаг. Хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхээс өмнө сэтгэцийн гэмтэлд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээний 5 зарчмыг судалж, үйлчилгээнд шингээхийг эрмэлзээрэй.

1. *Аюулгүй байдал* - Үйлчлүүлэгчид сэтгэл зүй болон орчны бүх талаар аюулгүй байна хэмээн мэдрэмжийг төрүүлэхийг эрмэлзэх.

2. **Ил тод, тодорхой байдал** - Сэтгэл зүйн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад үйлчлүүлэгчид эргэлзээ төрүүлэх аливаа зүйлсийг бий болгохгүй байх. Мэргэжлийн ёс зүй, хил хязгаарыг баримтлах.
  3. **Сонголтыг чухалчлах** - Эрх мэдэл, шийдвэр гаргах, үйлчилгээний бүхий л хэсэгт сонголт хийх боломжийг олгож, үйлчлүүлэгчийн шийдвэрийг хүндэтгэх
  4. **Хамтын ажиллагаа** - Үйлчлүүлэгчийн төлөө хийхгүй, үйлчлүүлэгчтэй хамтдаа ажиллана. Илаарьших үйл явц нь хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргалтаас эхэлдэг болохыг чухалчлах.
  5. **Хүчирхэгжүүлэх** - Үйлчлүүлэгчийн давуу байдал, хүч чадал, эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, давуу байдалд тулгуурлан үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх. Ур чадвар, давуу байдлыг байнга бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх. Үйлчлүүлэгчийн эрхэм чанар, халдашгүй байдал баталгаажих нөхцөлөөр хангах.
- Амиа хорлох бодол төрсөн, оролдлого хийсэн үйлчлүүлэгч айдас, түгшүүрт автсан, асуудлын шийдэлгүй, ганцаардсан, амьдрал нь утга учиргүй мэдрэмжтэй болсон байдаг. Иймээс сэтгэл зүйч аюулгүй, ирээдүйд асуудлууд шийдэгдэх боломжтой гэсэн мэдрэмжийг төрүүлэхэд анхаарах. Харилцааны хувьд нээлттэй асуух, буруутгах, шүүмжлэх, гайхах өнгө аяг бүхий үг хэллэг, биеийн хэлэмж харуулахгүй байхад анхаарах.
  - Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн болон бие махбодын талаас илэрч буй шинж тэмдгүүдийг нарийн анхаарах. Үйлчлүүлэгчээс асуух, ажигласан зарим шинжүүдийг үйлчлүүлэгчид хэлэх байдлаар тодруулж асуух. Шаардлагатай тохиолдолд (эмийн хордлогод орсон, ил шарх гэмтэлтэй байх гэх мэт) эмнэлгийн байгууллагын үйлчилгээг яаралтай санал болгоно.
  - Мэдрэмжээ чөлөөтэй илэрхийлэхэд саад болохгүй байх, жишээ нь, тайвшир, битгий уйл гэх мэт үгсийг ашиглахаас зайлсхийх.

### Сэтгэл зүйчийн хувийн бэлтгэлтэй холбоотой анхаарах зүйлс

- Сэтгэл зүйн тестийн заавар, үр дүнг гаргах аргыг эзэмшсэн байх, уулзалтын өмнө эцэг эх, асран хамгаалагч эсвэл үйлчилгээнд зуучилсан мэргэжилтнээс хүүхдийн нөхцөл байдлын тухай мэдээлэл авсан байх
- Сэтгэл зүйч уулзалтын өмнө өөрийн сэтгэл зүйг бэлтгэх: үйлчлүүлэгчийн асуудалтай адил өөрт тулгамдсан асуудлаа шийдвэрлэсэн, эсвэл ийм асуудалтай тулгарч байгаагүй байх, уулзалтын өмнө болон тухайн үед тайван элдэв айдас түгшүүргүй байх /хэрэв тийм бол зөвлөгөө өгөхөөс татгалзах/
- Хувцаслалт: ажил хэрэгч, хэт задгай буюу цээж, хөлийн хуруу, шагай ил гараагүй байх, гэрэлтээгүй, хэрэв юмка өмсөх бол өвдөгтэй чацуу болон өвдөгнөөс доош урттай юбкатай байх
- Нүүр будалт, гоёл: өдөр тутмын буюу хэт тод, гүн будалт хийхгүй байх, гоёл нь хэт чамин, гялгар, үнэтэй биш байх зэргийг шалгаж зохих хэмжээнд байлгахад анхаарна.

## СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЯВЦАД АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

### Сэтгэл зүйн арга, аргачлалыг ашиглах явцад анхаарах, бэлтгэх:

- Сэтгэл зүйн тест болон проектив аргуудыг ашиглаж үнэлгээ хийх явцад анхаарах:
  - o Тест болон бичих шаардлагатай үнэлгээний аргыг ашиглах тохиолдолд үйлчлүүлэгч унших, бичих боломжтой бол өөрөөр нь ажиллуулахыг санал болгоно. Хэрэв боломжгүй бол сэтгэл зүйч асууж, ярилцах замаар хариултыг бичнэ. Ингэхдээ байцаалт авч байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхгүй байх, асуултын агуулгаас гажсан тайлбар хийхгүй байх, үйлчлүүлэгчийн хариултыг чиглүүлэхгүй байх зэргийг мэргэжилтэн анхаарна.
  - o Хөтөлбөрт багтсан проектив аргуудыг ашиглахдаа үйлчлүүлэгчид картуудыг барьж үзэх, эргүүлж харах, зургуудад боловсруулалт хийх хугацааг олгоно. Проектив арга нь мэргэжилтнээс асуултыг оновчтой асуух, чиглүүлж ярилцах, эмпати чадвар зэргийг шаарддаг.
  - o Үйлчлүүлэгчид гэрийн даалгавар өгөх: Үйлчлүүлэгчид даалгаврыг санал болгохдоо түүний санал, сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл, дэмжлэг үзүүлэх боломжтой хүмүүс байгаа эсэх, амьдарч буй орчны нөхцөл байдал зэргийг харгалзан даалгаврыг өгнө. Ихэвчлэн хөнгөн, богино хугацаа шаардах ажлуудаас урт хугацаа шаардах ажууд руу бага зэрэг хүндрүүлж даалгаврыг өгнө. Үйлчлүүлэгч даалгаврыг гүйцэтгээгүй тохиолдолд хүндрүүлэхгүй байхыг анхаарах.

### Тэмдэглэл хийх, хөтлөхтэй холбоотой анхаарах зүйлс:

- Сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сэтгэл зүйн уулзалтын тэмдэглэлийн хуудас, сэтгэл зүйн үнэлгээний хуудас зэргийг хөтөлнө. Эдгээрийг хөтлөхдөө уулзалтын явцад өөрт сануулах үүднээс түлхүүр үг ашиглан тэмдэглэж, уулзалтын дараа түлхүүр үгсийг дэлгэрүүлэн бичихийг санал болгож байна. Учир нь үйлчлүүлэгчийн дэргэд байнга тэмдэглэл хөтлөх нь нээлттэй харилцаа үүсгэхэд хаалт болж болзошгүй.
- Уулзалтын тэмдэглэлийн хуудас хөтлөх /Хавсралт 1/:
  - o Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл. Энэ хэсэгт хамгаалах байр, НЦҮТ-ийн журмын дагуу үйлчлүүлэгчийн кейсийг кодолож үйлчлүүлэгчийн код хэсэгт тэмдэглэнэ. Мөн үйлчлүүлэгчийн нас, хүйсийг тэмдэглэж, тухайн үйлчлүүлэгч ямар хүчирхийлэлд өртсөний улмаас хамгаалах байр, НЦҮТ-өөр үйлчлүүлэх болсныг '✓' тэмдгээр тэмдэглэнэ.
  - o Үе шат, уулзалтын тэмдэглэл. Энэ хэсэгт хөтөлбөрт багтах уулзалт бүрийг явуулсан өдөр, уулзалтад ашиглаж буй сэтгэл зүйн арга техник, үнэлгээний үйл явц зэргийг тэмдэглэнэ. Мөн хамгаалах байр, НЦҮТ-ийн үйлчилгээний онцлогоос шалтгаалж дараагийн уулзалтыг өөр мэргэжилтэн чиглүүлэх боломжтой байдгийг харгалзаж дараагийн мэргэжилтэнд кейстэй хамааралтай анхаарах зүйл, сэтгэл зүйн арга аргачлалыг ашиглах явцад гарсан ажиглалт, үр дүнг тайлбар хэсэгт нарийн тэмдэглэж үлдээнэ.
  - o Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн. Энэ хэсэгт үйлчлүүлэгч сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдахаас өмнө хүчирхийллээс шалтгаалж (хүчирхийлэлтэй хамааралтай эсэхийг нарийн хэлэх боломжгүй тохиолдолд заавал хамааралтай байхыг шаардахгүй) бие махбод, сэтгэл зүй, зан үйлд илэрч буй илрэл, шинж тэмдэг, өөрчлөлтийг сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх явцад уулзалт бүрийн дараа тэмдэглэнэ. Мөн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид гарч буй үр дүн, ажиглалт, ахиц, суралцаж буй ур чадвар, дадал зэргийг үйлчлүүлэгчид гарсан сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн' хэсэгт тэмдэглэнэ. Хамгаалах байр, НЦҮТ-ийн үйлчилгээний онцлогоос шалтгаалж урт хугацааны сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, тодорхой үр дүнд хүрэхэд хязгаарлагдмал байх тул үр дүн хэсэгт том өөрчлөлтийг бичихээс илүү тухайн уулзалтын явцад болон дараа үйлчлүүлэгчид сэтгэл хөдлөл, мэдрэмж, бодлын түвшинд гарч буй багахан өөрчлөлтийг ажиглаж бичихэд хангалттай. Энэ нь кейс бүртгэлд шаардлагатайгаас гадна сэтгэл зүйчийг ажлаас халшрах хам шинжид өртөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

- Сэтгэл зүйн үнэлгээний хуудсыг сэтгэл зүйчийн болон үйлчлүүлэгчийн хөтлөх хуудсыг тус тусын зааврын дагуу хөтлөх:
  - o Сэтгэл зүйчийн ажлын хуудас: Сэтгэл зүйн үнэлгээний хуудаст тухайн хөтөлбөрийн туршид ашиглах арга, аргачлалын зорилго, онцлог, бэлтгэх зүйлс, үйлчлүүлэгчид тайлбарлах зааварчилгаа, үр дүнг тооцох аргачлал, тайлбарыг оруулсан. Сэтгэл зүйч урьдчилан тухайн сэтгэл зүйн үнэлгээний аргуудтай танилцаж, бэлтгэл ажлыг хангаж, уулзалтад ашиглана.
  - o Үйлчлүүлэгчийн ажлын хуудас: Үйлчлүүлэгчид шууд хэвлэн өгөхөөр бэлтгэсэн. Үнэлгээний асуулгын тайлбар болон тэмдэглэлийн хуудастай. Үр дүнгийн боловсруулалт, үнэлгээний үр дүнг оруулаагүй хуудас болно.

## НЭГ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх: :

- Гар самбар, бичгийн цаас, бал
- Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./
- Амиа хорлох оролдлогын үед үнэлгээ хийх хуудас /Хавсралт 2./
- Эрсдэлийн зэргийг үнэлэх нь /Хавсралт 3./
- Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл /Хавсралт 4./
- Эцэг эх, асран хамгаалагчид мэдээлэл өгсөн тухай хуудас /Хавсралт 5./
- Өсвөр насны хүүхэдтэй ярилцах загвар /Хавсралт 7./

### Уулзалтын зорилго:

- Амиа хорлох бодол санаа бүхий өсвөр насны хүүхэд эрсдэлийн үнэлгээ хийх, эцэг эх асран хамгаалагчтай холбогдох

АЛХАМ 1. Мэдээлэл авах, тодруулах / 15 хүртэл минут/	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Асран хамгаалагч эсвэл мэргэжилтний хамт ирсэн тохиолдолд “Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл” (Хавсралт 4)-ийн хуудсыг тэмдэглүүлэн нөхцөл байдлыг дараах чиглэлээр тодруулна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд ямар оролдлого хийсэн, эм уусан, гараа зүссэн гэх мэт.</li> <li>- Анхны тусламжийг хүүхэд өөрөө дуудсан эсэх, оролдлого хийх үед дэргэд нь хүн байсан эсэх,</li> <li>- Өмнө оролдлого хийж байсан эсэх,</li> <li>- Гэрийнхэндээ салах ёс хийж байгаа мэт үйлдэл илэрхийлж байсан эсэх,</li> <li>- Үхмээр байгаа тухай ярьж байсан эсэх,</li> <li>- Гэр бүлдээ хэн хэнтэйгээ амьдардаг,</li> <li>- Гэрийнхнээс хэн нэг нь оролдлого хийж байсан эсэх,</li> <li>- Оролдлого хийхийн өмнө ямар үйл явдал тохиолдсон,</li> <li>- Сэтгэцийн асуудлаас болж эмчид хандаж байсан эсэх, эм ууж байгаа эсэх г.м.</li> </ul>	<p>Нөхцөл байдлыг нарийвчлан тодруулах нь зүйтэй.</p> <p>Ингэхдээ хүүхдийн хажууд мэдээллийг асуухгүй байхыг анхаарах</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<p>Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл (Хавсралт 4) Түр хамгаалах байр, НЦҮТ-ийн журам, үйлчилгээний маягтуудын дагуу гэрээ байгуулна. Уулзалтын тэмдэглэлийн хуудасны дагуу тэмдэглэл хөтөлнө.</p>	

## АЛХАМ 2. Хүүхэдтэй холбоо тогтоох / 15 хүртэл минут /

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Сэтгэл зүйч өөрийгөө товч танилцуулна.</p> <p>Энгийн зүйлээс эхэлж ярилцана. Гэр, сургууль зэрэг ерөнхий хүрээний сэдвүүд байж болно. Хүүхэд арай тайван болох үед үндсэн асуултууд руу орно.</p> <p><i>Амиа хорлох бодолтой эсвэл оролдлого хийсэн эсэхээс хамааруулан<sup>6</sup> хүүхдээс асуух асуултаа сонгож болно.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Сэтгэл санааны байдал ямар байна?</li> </ul> <p>Хэрэв дуугарахгүй бол</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Санааг нь зовоосон асуудлууд хэр байна?</li> <li>○ Үнэхээр хэцүү үед үхэх тухай бодол орж ирдэг. Чамд өмнө нь ийм бодол орж ирсэн үү?</li> <li>○ Тэр үед яагаад ингэж бодсон?</li> <li>○ Сая санааг нь зовоохоор ямар зүйл тохиолдсон бэ? Яагаад ийм үйлдэл хийх болсон талаар. Юунд илүү сэтгэл өвдөж буй талаар.</li> </ul> <p>Мэдэх ёстой боловч шууд асуулт тавилгүйгээр мэдэж авах зүйл</p> <p>Төлөвлөсөн байдал, аргаа сонгосон эсэх, хугацаа товлосон эсэх, амиа хорлох тухай тэмдэглэл байгаа эсэх г.м. төсөөллийг тодорхой болгоход нөлөөлөх асуулт байж болохгүй.</p> <p>Ажиглах:</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Хүүхдийн харц, нүүрний хувирал, идэвх, хэт тайван байдал, гарын шуунд зүслэг бий эсэх,</li> <li>○ Шивээс, компьютер тоглодог шинж бий эсэх,</li> <li>○ Нойргүйдэл, бодис хэрэглэдэг байх боломжтой эсэх,</li> <li>○ Өөрийгөө хянах чадвартай байгаа эсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэл зүйн зөвлөгөөний өрөөнд хүүхдэд аюултай, дахин оролдлого хийхэд хэрэглэж болзошгүй эд зүйлс, хэрэгсэл, эсвэл сэдэл өгч болох зүйлс байгаа эсэхийг нягтална.</li> <li>- Сэтгэл зүйч хэт өрөвдсөн эсвэл сандарсан байдал харуулах нь сэтгэл зүйн хувьд холбоо тогтооход сөргөөр нөлөөлнө. Маш тайван, нөхөрсөг байдлаар яриагаа эхэлнэ.</li> <li>- Амиа хорлох бодол үнэхээр тогтвортой төрсөн эсэх, оролдлого хийж байсан эсэхийг эхлээд нягталж мэдэх нь чухал. Учир нь зөвхөн бодол төрж байсан хүүхдэд асуултаараа сэдэл өгөх тохиолдол байдаг. Иймд амиа хорлох бодлын тухай ярилцах хэрэгтэй. Төлөвлөгөө, хугацаа гэх мэт нарийн зүйлс асууж болохгүй.</li> <li>- Харин амиа хорлох бодол тогтвортой төрсөн, оролдлого хийсэн гэдгийг мэдсэн бол шууд болон шууд бус замаар төлөвлөгөө, хугацаа, ямар аргаар зэргийг тандаж мэдсэнээр дараагийн шатны арга хэмжээг авах эсэхээ төлөвлөнө.</li> </ul>

## АЛХАМ 3. Сэтгэл зүйн үнэлгээ хийх / 25-30 хүртэл минут /

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Амиа хорлох эрсдэл бүхий хүүхдэд сэтгэл зүйн үнэлгээ хийх нь нэн тэргүүний ажлын нэг тул анхны уулзалтаар үнэлгээг хийх шаардлагатай. Сэтгэл зүйн үнэлгээг хийснээр эрсдэлийг бодитоор үнэлж анхан дунд болон өндөр эрсдэлийг тооцоолж үйлчилгээг төлөвлөхөд тустай байдаг.</p> <p>Сэтгэл зүйн үнэлгээ хийхдээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Нийлэмжийн арга</li> <li>○ Түргэвчилсэн асуулга</li> <li>○ MAST</li> <li>○ RES асуулгуудыг ашиглана.</li> </ul> <p><i>Жич: ЭМС-ын 2022 оны 3 сарын 18-ны А149 тоот тушаалаар батлагдсан аргачлалуудыг ашиглаж болно.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд асуулгад үнэн бодитой хариулах хэмжээнд сэтгэл зүйн болон бие махбодын тогтвортой байдалтай байгаа эсэхийг ажиглах</li> <li>- Хэрвээ тогтворгүй, сэтгэл хөдлөл ихтэй байвал амьсгалын дасгал, булчин суллах дасгал, хөгжим сонсох гэх мэтээр тайвшруулах дасгал хийх</li> <li>- Бие махбодын хувьд шокын байдалтай байвал шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлэх</li> <li>- Орчны нөлөөлөх хүчин зүйлс байгаа эсэхэд анхаарах</li> </ul>



**Нийлэмжийн арга:** Энэхүү арга нь шинжлүүлэгчид тухайн мөчид ямар нийлэмж зонхилон үүсэж байгааг илрүүлдэг.

**Онцлог:** Хэрэглэхэд хялбар, богино хугацаанд шинжлүүлэгчийн талаар нарийн мэдээлэл авах боломжтой тусгалын арга юм. Судлаачаас ур чадвар шаардана.

**Заавар:** Санаандаа орсон үгнүүдийг аль болох бодолгүй, түргэн нэрлэнэ үү. (Ойролцоогоор 50-60 үг бичүүлнэ, эсвэл нэрлүүлнэ)

Үр дүнг боловсруулах. Дараах үзүүлэлтүүдийн дагуу дүгнэнэ. Үүнд:

- Үг нэрлэх, бичих хурд
- Сэтгэл хөдлөл шингэсэн үг, эерэг, сөрөг агуулга бүхий үг хэр их байна
- Тэмдэг нэр хэр их ашигласан байна
- Хүнтэй холбоотой үг
- Амиа хорлох төлөвлөгөө, хэрэглэгдэхүүн гэж үзэж болох үг хэр байна гэх мэт агуулгын дагуу бага, дунд, өндөр гэж үнэлнэ.

**Түргэвчилсэн асуулга:** Амиа хорлох бодол, төлөвлөгөө, үйлдэл байгаа эсэхийг илрүүлэхэд чиглэсэн. Сэтгэл зүйч ярилцлагын явцад авсан мэдээллийн дагуу өөрөө тэмдэглэж үнэлнэ.

**Онцлог:** Үндсэн 4 асуулттай, хэрэглэхэд хялбар. ДЭМБ-аас боловсруулсан.

Үр дүнг боловсруулах. Аль нэг асуултад тийм гэж хариулсан бол эрсдэлтэй гэж үзнэ.

**MAST аргачлал:** Амьдрах эсвэл үхэх талаар бодлын аль нь давамгайл байгааг илрүүлэхэд чиглэнэ.

**Онцлог:** Түгээмэл хэрэглэдэг, харьцангуй цөөн даалгавартай.

**RES асуулга:** Өөрийн үнэлэмж хэр байгааг судлахад чиглэсэн.

**Онцлог:** Цөөн асуулгатай учир богино хугацаанд үнэлгээ хийхэд тохиромжтой.

## Анхааруулга

*Сэтгэл зүйн үнэлгээнд хэрэглэгдэх аргуудын түлхүүрийг мэргэжлийн бус хүн болон олон нийтэд мэдээлэх, тараахыг хориглоно.*

*Энэ нь тест өгөх үед сэдэл өгөх, үр дүнд зориудаар нөлөөлөх эрсдэлтэй.*

## Хэрэглэгдэхүүн / Арга барил

- Хариултын хуудас
- Эрсдэлийн зэргийг үнэлэх нь /Хавсралт 3./

#### АЛХАМ 4. Дэмжлэг үзүүлэх / 5-10 хүртэл минут /

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, дараагийн уулзалтад ирэх сэдлийг өгөх зорилгоор ярилцлагын төгсгөлд энгийн, нөхөрсөг байдлаар дэмжлэг үзүүлсэн хэллэг хэрэглэнэ. Олон өгүүлбэр байж болохгүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Чи их хэцүү мэдрэмжийг даван туулж байна, тэвчээртэй хүү, охин байна.</li> <li>- Ийм оролдлого дахиж хийхгүй гэж амлаарай, би (эгч нь), бид чамд туслахыг хүсэж байна. Үүнд хугацаа хэлэх нь зүйтэй байдаг, жишээ нь, 3 сар г.м. бичүүлж авч болно. Нэмэлт жишээг Хавсралт 7. -оос харна уу.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хоосон магтаал биш чин сэтгэлээсээ зоригжуулах нь зүйтэй. Оролдлого хийсэн хүүхдийн эрсдэлийг бага гэж үнэлсэн тохиолдолд дараачийн уулзалтыг 3-7 хоногийн дотор хийж болно.</li> <li>- Зарим тохиолдолд сэтгэл зүйчийг дахин харах нь хэцүү үеийн мэдрэмжийг сэргээх эрсдэлтэй байдаг.</li> </ul>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- <i>Өсвөр насны хүүхэдтэй ярилцах загвар /Хавсралт 7./</i></li> </ul>	

#### АЛХАМ 5. Эцэг эхэд мэдээлэх / 5-10 хүртэл минут /

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдэд хийсэн сэтгэл зүйн үнэлгээний үр дүн, хүүхдийн сэтгэл зүйн байдал, эрсдэлийн зэрэг ямар байгааг танилцуулсан хуудсыг тэмдэглэн танилцуулж гарын үсэг зуруулж ямар үйлчилгээнд хамруулах талаар мэдээлэл өгнө.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд эрсдэлийн үнэлгээгээр <b>бага болон дунд</b> эрсдэлтэй гарсан бол энэхүү хөтөлбөрийн дагуу сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө, тусламж үйлчилгээг хүргэнэ.</li> <li>- Хүүхдийн эрсдэлийн үнэлгээ <b>өндөр</b> гарсан тохиолдолд эцэг эхэд мэдэгдэж дараагийн шатны тусламж үйлчилгээнд хамруулах шаардлагатайг танилцуулж хаана хандаж үйлчилгээ авч болох талаар мэдээллийг өгнө.</li> </ul> <p>Үүнд: Харьяа дүүргийн ЭМТ, СЭМҮТ</p>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- <i>Эцэг эх, асран хамгаалагчид мэдээлэл өгсөн тухай хуудас /Хавсралт 5./</i></li> </ul>	

## ХОЁР. МЭДРЭМЖ ГАДАГШЛУУЛАХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх:

- Гар самбар, бичгийн цаас, бал, мэдрэмж гадагшлуулах карт, Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1/



### Уулзалтын зорилго:

- Хүүхдийн үндсэн асуудлаас үүдэлтэй мэдрэмжийг гадагшлуулж, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, мэдрэмжийг гадагшлуулахад чиглэнэ.

АЛХАМ 1. Холбоо тогтоох /10 хүртэл минут /	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Нууцыг хадгалах тул төрж буй бодол, мэдрэмжээ аль болох нээлттэй ярихыг хичээгээрэй гэж хэлнэ.</li> <li>- Хүүхэд өөрийн асуудлыг илэн далангүй ярьж эхэлбэл холбоо тогтож байна гэж үзнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Амиа хорлох эрсдэл <b>дунд болон түүнээс доош</b> байгаа үед энэ шатанд шилжинэ.</li> <li>- Зөвлөгөөний өрөөний аюулгүй байдлыг буюу хүүхдэд амиа хорлох оролдлого хийж болохуйц болон оролдлого хийхэд ашигласан зүйлс, болон сэдэл өгч болзошгүй түүнтэй төстэй зүйлс байгаа эсэхийг нягтална.</li> <li>- Сэтгэл зүйчийн дууны өнгө, биеийн хэлэмж, хандлага, өмнөх уулзалтаар тогтоосон итгэлцэл зэрэг нь энэ уулзалт болон дараагийн уулзалтын туршид үйлчлүүлэгч хэр зэрэг илэн далангүй ярихад нөлөөлөх тул энэхүү уулзалтын эхэнд тэмдэглэгдсэн бэлтгэл зүйлсийг нягтлан өөрийгөө бэлтгэхэд анхаараарай.</li> </ul>
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.</li> </ul>	

АЛХАМ 2. Мэдрэмж гадагшлуулах / 25 хүртэл минут /	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Дараах чиглэлийн дагуу ярилцана.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Одоо юу мэдэрч байна? Бие махбодын хувьд, сэтгэл санааны хувьд.</li> <li>- Энэ мэдрэмж хэзээнээс үргэлжилсэн, хэр удаж байна?</li> <li>- Юу чамайг эмзэглүүлсэн бэ?</li> </ul> <p>Хүүхэд ярианд идэвхтэй биш байвал гэр бүл, сургууль найз нөхөд аль нь болохыг тодруулна.</p> <p>Энд хүргэсэн нөхцөл байдал, үйл явдлын талаар ярьж болох эсэхийг асууна.</p> <p>Бага насны сайхан дурсамж, хүсэл мөрөөдөл, хобби, сонирхол, амжилт, хэнд илүү хайртай гэх мэт эерэг сэдвүүд рүү орж ярилцана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийг үргэлжлүүлэн ярьж байх үед таслахгүйгээр, анхааралтай сонсоно.</li> <li>- Ярьж байгаад дуугүй болох үед өдөөх асуулт тавьж болно.</li> <li>- Хэт хувийн чанартай зүйлс рүү “ухаж” ярилцахгүй байх, эерэг тал руу илүү ярилцахыг эрхэмлэх.</li> <li>- Тайвшруулах гэж хэт хичээх хэрэггүй.</li> <li>- Бүх зүйл сайхан болно гэж амлах хэрэггүй.</li> <li>- Өөрөө өөдрөг, эрч хүчтэй, халшраагүй байх нь чухал.</li> <li>- Хүүхдэд амиа хорлох тухай бодол бий болоход нөлөөлсөн таагүй шалтгааны талаар 40 минутаас илүү яриулж болохгүй.</li> </ul>

## Хэрэглэгдэхүүн / Арга барил

Мэдрэмжийн картууд ашиглаж болно. Жишээ нь, Банхар карт, Ийкүү карт

## АЛХАМ 3. Баталгаажуулалт, дүгнэлт / 5 хүртэл минут /

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Үйлчлүүлэгчийн ярианаас анзаарсан сайн чанарыг бататгаж хэлнэ. Чамд ийм сайн чанарууд, ирээдүйг төсөөлсөн өөдрөг бодол төсөөллүүд байгааг сонслоо. Тиймээс эдгээр өөдрөг бодол төсөөллийг улам батжуулж, ирээдүйд биелүүлэх оролдлогыг хийнэ гэдэгт найдаж байна. Энэ тухай үргэлжлүүлэн дараагийн уулзалтаар ярилцах уу? гэж асууж хариултыг авна.</p> <p>Дараагийн уулзалтыг товлон.</p>	<p>Үйлчлүүлэгчийн мэдрэмж хэр зэрэг илэрхийлэгдэж гарсан, уулзалтын төгсгөлд таагүй мэдрэмж төрж үлдээгүй эсэхийг анзаарна. Таагүй мэдрэмжийг яриулж дуусгаж болохгүй. Иймд мэдрэмжийг хаах буюу заавал эерэг зүйлсийг яриулж дуусгана. Уулзалтын төгсгөлд таагүй, өвтгөсөн зүйлсээ яриад дуусгавал үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн асуудал сэдэрч, гараад дахин гутрах, амиа хорлох оролдлого хийх эрсдэлтэй.</p>

## ГУРАВ. СЭТГЭЛ ЗҮЙН НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх:

- Гар самбар, бичгийн цаас, бал
- Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./
- Нөөц метафор карт



### Уулзалтын зорилго:

- Үйлчлүүлэгчийн амиа хорлох бодол санааг багасгах
- Үйлчлүүлэгчийг идэвхтэй байх нөхцөлийг бүрдүүлсэн зураглал гарахад туслах, юуг хийж болох зүйлсийг санал болгох, тууштай хийхэд дадал болгосноор эрч хүчийг нэмэгдүүлэх.

АЛХАМ 1. Холбоо тогтоох /10 хүртэл минут /	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Өнгөрсөн өдрүүдэд сэтгэл санаа, мэдрэмж ямар байсан талаар ярилцана.</li> <li>- Харилцаа болон сэтгэл хөдлөлийн байдалд өөрчлөлт гарч байгаа эсэх талаар ярилцана.</li> <li>- Санааг нь зовоож буй асуудлын талаар ярилцана.</li> </ul> <p>Хэрэв ямар нэг нааштай өөрчлөлт, ахиц байгаа бол түүнийг бататгаж дүгнэнэ. Ийм өөрчлөлт гарч байгаа нь сайн байна г.м.</p> <p>Хэрэв юу ч өөрчлөгдөөгүй байгаа бол цаг хугацааны явцад аяндаа сайжирна гэж бодож байна, би чамд итгэж байна гэх мэтээр дэмжинэ.</p>	<p>Зөвлөгөөний өрөөний аюулгүй байдлыг буюу хүүхдэд амиа хорлох оролдлого хийж болохуйц болон оролдлого хийхэд ашигласан зүйл болон сэдэл өгч болзошгүй түүнтэй төстэй зүйлс байгаа эсэхийг нягтална.</p> <p>Сэтгэл зүйчийн дууны өнгө, биеийн хэлэмж, хандлага, өмнөх уулзалтаар тогтоосон итгэлцэл зэрэг нь энэ уулзалт болон дараагийн уулзалтын туршид үйлчлүүлэгч хэр зэрэг илэн далангүй ярихад нөлөөлөх тул энэхүү уулзалтын эхэнд тэмдэглэгдсэн бэлтгэл зүйлсийг нягтлан өөрийгөө бэлтгэхэд анхаараарай.</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
Уулзалт бүр дээр хөтөлж буй “Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.	

АЛХАМ 2. Метафор карт ашиглаж ярилцах / 20 хүртэл минут /	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Метафор картын тусламжтай ярилцах.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нөөцийн картуудыг ашиглана.</li> </ul> <p>Сэтгэл зүйч картыг нээлттэй хэлбэрээр дэлгэж өөрт таатай харагдаж байгаа 3 зургийг сонгуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн зургийг яагаад сонгосон</li> <li>- Ямар мэдрэмж төрүүлж байна</li> <li>- Зурагтай холбоотой үйл явдал тохиолдож байсан эсэх</li> <li>- Тэр үед ямар мэдрэмж төрсөн</li> <li>- Дараагийн уулзалт хүртэл аль нэгийг туршиж үзэх боломжтой эсэх зэрэг чиглэлээр ярилцана.</li> </ul>	<p>Зурган картыг ашиглаж үйлчлүүлэгчтэй ярилцахад карт болон үйлчлүүлэгчийн тухай нээлттэй асуултуудыг асууж, чиглүүлэх байдлаар ярилцлагыг өрнүүлдэг. Ингэхдээ хаалттай, тулгасан асуулт асуух нь зохимжгүй. Мөн зурган карт нь хаалттай үйлчлүүлэгчийн мэдрэмжийг гадагшлуулахад тустай байдаг.</p> <p>Картыг бүтээлч байдлаар олон төрлөөр ашиглаж болох бөгөөд өнөөдрийн сэтгэл хөдлөл, нөхцөл байдлыг илэрхийлэхүйц картыг сонгож ярилцах гэх мэтээр нээлттэйгээр ашиглаж болно.</p>

**Хэрэглэгдэхүүн / Арга барил**

- Метафор карт

**АЛХАМ 3. Баталгаажуулалт, дүгнэлт / 10 хүртэл минут /****Зааварчилгаа**

Өнөөдрийн уулзалт ямар санагдсан тухай ярилцана.

Гэрийн даалгаварт карт дээрх сонголтуудаас аль нэгийг хийж туршсан байхыг санал болгоно. Намайг юу сэтгэл хангалуун болгодог вэ гэсэн асуултад өдөр бүр 2 зүйл бичиж ирэхийг санал болгоно.

**Хэрэглэгдэхүүн / Арга барил**

Аз жаргалтай болгодог зүйлсийн талаар жагсаалт бичих хуудас

## ДӨРӨВ. ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ УУЛЗАЛТ



### Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх:

- Гар самбар, бичгийн цаас, бал, Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./
- Цаашдын төлөвлөгөө гаргах хуудас /Хавсралт 8./



### Уулзалтын зорилго:

- Энэхүү уулзалтаар хүүхдийг тодорхой хугацааны зорилготой болгох, цаашид хэрхэн идэвхтэй байх талаар сэдэл төрүүлэхэд чиглэнэ.

АЛХАМ 1. Сэргээн санах / 10 хүртэл минут /	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>- Зураг дээрх үйл явдлыг туршиж үзсэн эсэх тухай, ямар мэдрэмж төрүүлсэн талаар ярилцана.</li> <li>- Юу сэтгэл хангалуун болгож буй талаар жагсаалтын талаар ярилцана. Энэ хэсгийг тогтож ярилцах нь зүйтэй.</li> </ul>	<p>Зөвлөгөөний өрөөний аюулгүй байдлыг буюу хүүхдэд амиа хорлох оролдлого хийж болохуйц болон оролдлого хийхэд ашигласан зүйлс, болон сэдэл өгч болзошгүй түүнтэй төстэй зүйлс байгаа эсэхийг нягтална.</p> <p>Сэтгэл зүйчийн дууны өнгө, биеийн хэлэмж, хандлага, өмнөх уулзалтаар тогтоосон итгэлцэл зэрэг нь энэ уулзалт болон дараагийн уулзалтын туршид үйлчлүүлэгч хэр зэрэг илэн далангүй ярихад нөлөөлөх тул энэхүү уулзалтын эхэнд тэмдэглэгдсэн бэлтгэл зүйлсийг нягтлан өөрийгөө бэлтгэхэд анхаараарай.</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> <li>- Уулзалт бүр дээр хөтөлж буй “Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.</li> </ul>	

АЛХАМ 2. Төлөвлөгөө / 25 хүртэл минут /	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Хүүхдийн идэвх, сэтгэл санааны байдлаас хамааруулан ойрын 14 хоногт юу хийх талаар төлөвлөгөөг хамтран ярилцаж гаргана. Хугацаа 10-14 хоногоор байх нь оновчтой байдаг.</p> <p>Төлөвлөгөөний биелэлтийг тэмдэглэх хуудас өгнө.</p> <p>Төлөвлөгөө нь сонирхолтой, хөгжилтэй байх ба хэт ачаалал дарамттай мэдрэмж өгч болохгүй. Мөн маш тодорхой зааж өгөх нь зүйтэй.</p>	<p>Сэтгэл зүйч тодорхойгүй зүйл байвал тодруулж ярилцана. Жишээ нь, ном уншина гэвэл ойрд уншиж амжаагүй ямар ном байгаа вэ, аль номыг нь уншъя гэж бодож байна, эсвэл хэнтэй номын дэлгүүр орох уу, хэзээ гэхчлэн маш тодорхой төсөөлөлтэй болгоход анхаарна.</p> <p>Хавсралт 8-ыг хоосон болон жишээ төлөвлөгөө бүхий 2 хуудас оруулав. Хүүхдэд тайлбарлаад хүүхэд өөрөө санаа, төлөвлөгөөг гаргах идэвхтэй бол нээлттэй бүтээлчээр гаргавал сайн тул хоосон хувилбарыг ажиллана. Харин хүүхэд идэвхгүй байвал санал болгох маягаар жишээ дурдагдсаныг өгч ажиллана.</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> <li>- Уулзалт бүр дээр хөтөлж буй “Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.</li> </ul>	

### АЛХАМ 3. Баталгаажуулалт, дүгнэлт / 15 хүртэл минут /

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Уулзалтын төгсгөлд ийм ийм давуу тал ажиглагдаж байна, мөн цаашид өөрийгөө сэтгэл хангалуун болгодог зүйлсийн жагсаалтыг 60 орчим хүргэх, төлөвлөгөөгөө дор хаяж 3 сар үргэлжлүүлж хийх тухай хэлнэ.</p> <p>Сэтгэл санаа хэцүү үед гэртээ хэнтэй ярилцаж чадах, болохгүй бол хэзээд уулзахаа дуртай байх болно гэсэн байдлаар уулзалтыг өндөрлүүлнэ.</p>	Өөрийн дуртай, өөрт таатай санагдаж буй зүйлсийг тогтмол хийх нь сэтгэл санааны тогтвортой байдалд сайн.
<b>Хэрэглэгдэхүүн / Арга барил</b>	
- Хавсралт 1. Уулзалтын тэмдэглэлийн хуудас	

## ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ

Хөтөлбөрийн үр дүнг Хавсралт 1. “Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ын дагуу үйлчлүүлэгчтэй хийх уулзалт бүрийн явцад хөтөлнө. Үүнд:

- Эхний сэтгэл зүйн уулзалтын дараа ‘Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл’,
- Уулзалт бүрийн явцад ‘Үе шат, уулзалтын тэмдэглэл’

Дөрөв дэх уулзалтын төгсгөлд “Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн” хэсгийн дагуу тэмдэглэл хийж, үйлчлүүлэгчид үзүүлсэн сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн, ахицыг үнэлнэ.

## ТУЛГАРЧ БОЛОХ БЭРХШЭЭЛ, ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИ

Тулгарч болзошгүй бэрхшээл	Даван туулах стратеги
<i>Үйлчлүүлэгч ил харагдах гэмтэл, шархтай байх эсвэл шокын байдалтай байх гэх мэт тохиолдолд яах вэ?</i>	<p>Эцэг эх асран хамгаалагчтай ирсэн тохиолдолд яаралтай мэдээлэл авч эмнэлгийн байгууллагын тусламж үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна.</p> <p><b>Анхаар:</b> Үйлчлүүлэгчийн гэмтэл, одоогийн биеийн байдал ямар байгааг маш сайн тодруулна. Яг одоо амьсгал авч чадахгүй давчдах, нүүр бие хөхрөх, цонхийх, татах, бөөлжих, цус алдах, эмийн хордлогод орсон байж болзошгүй гэх мэт ноцтой шинж тэмдгийн үед эмнэлгийн тусламж үзүүлэхэд анхаарч чиглүүлнэ. Харин зүслэгийн шарх тавлаж эхэлсэн, цус бага зэрэг шүүрсэн гэх мэт тохиолдолд зөвлөгөөг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.</p>
<i>Сэтгэл зүйн зөвлөгөөний өрөөнд амиа хорлох оролдлого хийвэл яах вэ?</i>	<p>Амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд хамт ирсэн хүнд яаралтай мэдэгдэж, шаардлагатай анхан шатны болон мэргэжлийн байгууллагын тусламжийг хүргэнэ.</p> <p><b>Анхаар:</b> Сэтгэл зүйн зөвлөгөөний өрөөнд үйлчлүүлэгчид аюултай, дахин амиа хорлох оролдлого хийх эд зүйлс, хэрэгсэл болох зүйлс болон сэдэл өгч болох зүйлс байгаа эсэхийг нягтална.</p>



<p><i>Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай нь ажиглагдаж байгаа хэдий ч үйлчлүүлэгч сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдахыг хүсэхгүй байгаа тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үйлчилгээний зорилго, ач холбогдол, үр дүнг нас, сэтгэхүйн онцлогт нь тохиромжтой байдлаар тайлбарлаж өгнө. Хэрэв үйлчлүүлэгч өмнөх сэтгэл зүйн үйлчилгээнээс шалтгаалж мэргэжилтэнд итгэх итгэл буурсан бол үйлчилгээнд баримтлах хил хязгаар, ёс зүйн хэм хэмжээг тайлбарлаарай. Сэтгэл зүйч үйлчилгээг хангалттай тайлбарлаж чадсан хэмээн үзвэл үйлчлүүлэгчид шийдвэр гаргах боломжийг олгоорой.</p> <p><b>Анхаар:</b> Үйлчлүүлэгчид үр дүнг тайлбарлахдаа амлалт өгөхөөс зайлсхийгээрэй. Үүний оронд үйлчилгээний явцад ямар эерэг үр дүнд чиглэх, үүний тулд хэрхэн хамтран ажиллах тухай тайлбарлаарай.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчийн үг, үйлдэлд огт хариу үйлдэл үзүүлэхгүй байвал яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал, харилцааны онцлог, сэтгэл зүйн цочрол, түүний илрэл зэрэг олон зүйлсээс хамаарч зан үйл, хариу үйлдэл шалтгаална. Иймээс үйлчлүүлэгчийн чимээгүй байх, сэтгэл зүйчид харилцан үйлдэл үзүүлэхгүй байх нь үйлчилгээг хүсэхгүй байна гэсэн илэрхийлэмж болохгүй.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчид итгэхгүй байх тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Иймээс сэтгэл зүйч өөр өөр арга техникийг үйлчлүүлэгчид санал болгож, хэт тулгаж, яарахгүйгээр үйлчилгээг үргэлжлүүлээрэй. Зарим үед үйлчлүүлэгчтэй хамт чимээгүй суух, ямар нэгэн зүйлсийг ажиглах, зураг зурах, сараачих зэргээр идэвхтэй биш аргуудыг ашиглаарай.</p> <p><b>Анхаар:</b> Үйлчлүүлэгчийн идэвхгүй байдлыг үйлчилгээнээс татгалзаж байна хэмээн дүгнэлт хийж, үйлчилгээг зогсоож болохгүй бөгөөд хариу үйлдэл бүр ялгаатай байж болно гэдгийг санаарай.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчид итгэхгүй байх тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчийн туулсан туршлагаас шалтгаалж харилцаанд итгэл алдрах, аюултай байдлыг мэдрэх нь хэвийн хариу үйлдэл. Иймээс мэргэжилтэнд итгэх итгэл үүсэх нь урт хугацаа шаардах тул түүнд аюулгүй байдлыг мэдрэх боломжтой орчин, харилцааг бий болгож сонголтыг өгч үйлчилгээг үргэлжлүүлнэ.</p>
<p><i>Хөтөлбөрт дурдсан арга техникийг ашиглах, сэтгэл зүйн үнэлгээг хийлгэхээс татгалзсан тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Хэрэв үйлчлүүлэгч сэтгэл зүйчийн санал болгосон арга техникийг ашиглахаас татгалзсан тохиолдолд түүнд боломжит сонголтуудыг олгож, нээлттэй асуух байдлаар үйлчилгээг үргэлжлүүлнэ.</p> <p><b>Анхаар:</b> Үйлчлүүлэгчид тулгах, үүнээс өөр арга байхгүй мэт шаардах зэрэг нь сэтгэл зүйчид итгэх итгэлийг бууруулдаг. Хэрэв сэтгэл зүйчид өөр санал болгох арга техник байхгүй бол үйлчлүүлэгчид үнэн байдлаа хэлж дараагийн уулзалт дээр бэлтгэлтэй байхын тулд юу хийхийг хүсэж байгааг нь асууж ярилцана.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчид хэт дасах, хамааралтай байдал ажиглагдсан тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Нэг талаар сэтгэл зүйч үйлчилгээ үзүүлэхдээ ёс зүйн зарчим дахь хил хязгаарыг хангалттай баримтлаагүй тохиолдолд, нөгөө талаар үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн онцлогоос шалтгаалж сэтгэл зүйчид дасах байдал ажиглагдаж болно. Энэ тохиолдолд сэтгэл зүйч үйлчилгээнд хил хязгаарыг баримталж, хувийн харилцаа биш мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгааг үйлчлүүлэгчийн насны онцлогт тохирсон байдлаар ойлгуулна. Мөн уулзалт бүрийн дараа даалгавар өгөх, уулзалтын хугацааг тогтмол байлгах, сэтгэл зүйчгүйгээр сэтгэл зүйн асуудлаа даван туулах дадлыг бэхжүүлэхийг хичээнэ.</p>

## УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУУДАС

### 1. Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл

Үйлчлүүлэгчийн код:	_____
Нас, хүйс:	_____, _____
Ирсэн шалтгаан:	- Амиа хорлох бодол санаа - Амиа хорлох оролдлого хийсэн Бусад _____
Өөрийн санаачилгаар ирсэн эсэх:	- Тийм - Үгүй Тайлбар _____
Хэнтэй ирсэн:	- Ганцаараа - Асран хамгаалагчийн хамт - Багш, сурган хүмүүжүүлэгч - Хамтарсан баг - _____

### 2. Үе шат, уулзалтын тэмдэглэл

№	Арга, техник	Тэмдэглэгээ	Тайлбар
Уулзалтын үе шат: Код 4-1		Огноо: ____/____/____	
1	“Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл” авсан эсэх	- Тийм - Үгүй	
2	Нөхцөл байдлыг тодруулах: <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд ямар оролдлого хийсэн, эм уусан, гараа зүссэн гэх мэт.</li> <li>- Анхны тусламжийг хүүхэд өөрөө дуудсан эсэх, оролдлого хийх үед дэргэд нь хүн байсан эсэх,</li> <li>- Өмнө оролдлого хийж байсан эсэх,</li> <li>- Гэрийнхэндээ салах ёс хийж байгаа мэт үйлдэл илэрхийлж байсан эсэх,</li> <li>- Үхмээр байгаа тухайгаа ярьж байсан эсэх,</li> <li>- Гэр бүлдээ хэн хэнтэйгээ амьдардаг,</li> <li>- Гэрийнхнээс хэн нэг нь оролдлого хийж байсан эсэх,</li> <li>- Оролдлого хийхийн өмнө ямар үйл явдал тохиолдсон,</li> <li>- Сэтгэцийн асуудлаас болж эмчид хандаж байсан эсэх, эм ууж байгаа эсэх г.м.</li> </ul>		

3	Ажиглах: - Хүүхдийн харц, нүүрний хувирал, идэвх, хэт тайван байдал, гарын шуунд зүслэг бий эсэх, - Шивээс, компьютер тоглодог шинж бий эсэх, - Нойргүйдэл, бодис хэрэглэдэг байх боломжтой эсэх, - Өөрийгөө хянах чадвартай байгаа эсэх		
4	Сэтгэл зүйн үнэлгээ: - Нийлэмжийн арга		
	- Түргэвчилсэн асуулга	Тийм: _____	
	- MAST	AL 7 _____ RL 7 _____ AD 7 _____ RD 9 _____	
	- RES Доогуур оноо нь өөрийн үнэлгээ нь өндөр болохыг илэрхийлдэг. Дээд оноо 40	40-өөс _____	
5	Эрсдэлийн зэрэг	<ul style="list-style-type: none"> <li>• Өндөр</li> <li>• Дунд</li> <li>• Бага</li> </ul>	
Уулзалтын үе шат: Код 4-2      Огноо: _____ / _____ / _____			
1	Мэдрэмжийн карт ашигласан эсэх	- Тийм - Үгүй	
2	ТЭМДЭГЛЭЛ		
Уулзалтын үе шат: Код 4-3      Огноо: _____ / _____ / _____			
1	Нөөцийн карт ашигласан эсэх	- Тийм - Үгүй	
2	Аз жаргалтай болгодог зүйлсийн талаар жагсаалт бичих хуудас даалгаварт өгсөн эсэх	- Тийм - Үгүй	
3	ТЭМДЭГЛЭЛ		
Уулзалтын үе шат: Код 4-4      Огноо: _____ / _____ / _____			
1	Цаашдын төлөвлөгөө гаргах хуудас тэмдэглэсэн эсэх	- Тийм - Үгүй	
2	ТЭМДЭГЛЭЛ		

### 3. Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн

Үйлчлүүлэгчид гарсан сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн		
Бие махбод, сэтгэл зүй, зан үйлд гарсан эерэг үр дүн	Сэтгэл зүйн үйлчилгээний явцад суралцсан чадвар, итгэл үнэмшил, ахиц	Мэргэжилтний дүгнэлт болон үйлчлүүлэгчийн сэтгэгдэл

## СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

*(Сэтгэл зүйчийн ажлын хуудас)*

Үйлчлүүлэгчийн код: \_\_\_\_\_

### 1. Нийлэмжийн сорил

Заавар:

*Санаандаа орсон үгнүүдийг аль болох бодолгүй, түргэн нэрлэнэ үү. (Ойролцоогоор 50-60 үг бичүүлнэ, эсвэл нэрлүүлж, сэтгэл зүйч бичиж авна)*

Үр дүнг боловсруулах. Дараах үзүүлэлтүүдийн дагуу дүгнэнэ.

№	АГУУЛГА	БАГА	ДУНД	ӨНДӨР
1	Үг нэрлэх, бичих хурд			
2	Сэтгэл хөдлөл шингэсэн үг, эерэг, сөрөг агуулга бүхий үг хэр их байна			
3	Тэмдэг нэр хэр их ашигласан байна			
4	Хүнтэй холбоотой үг			
5	Амиа хорлох төлөвлөгөө, хэрэглэгдэхүүн гэж үзэж болох үг хэр байна			
Ерөнхий үнэлгээ “✓” тэмдэглэгээг хийнэ үү.				

### 2. Түргэвчилсэн асуулт

Үйлчлүүлэгчтэй ярилцах явцдаа сэтгэл зүйч өөрөө олсон мэдээллийн дагуу тэмдэглэж үнэлнэ.

	Асуулт	Хариулт
1	Амиа хорлох болон буюу үхэх бодолтой эсэх	
2	Амиа хорлох тусгай төлөвлөгөөтэй эсэх	
3	Өнгөрсөн хугацаанд амиа хорлох ноцтой оролдлого хийж байсан эсэх	
4	Бусдын амь насанд хор хөнөөл учруулах бодолтой эсэх	

**Тайлбар:** Эдгээр асуултуудыг ярилцлагын явцад олж мэдсэнээр тэмдэглэж авч болно.

Асуултуудын аль нэгэнд “тийм” гэсэн хариулт өгч байгаа тохиолдолд “амиа хорлох эрсдэлтэй” хэмээн тооцож, түүнээс сэргийлэх зорилгоор уг өвчтөнийг хэн нэг ойр дотны хүний байнгын хараа хяналтад байлгах буюу эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай.

### 3. MAST аргачлал

Үр дүн

		N	Нийлбэр оноо	Даалгаварт харьцуулсан оноо
AL	Амьдралд татагдах	1, 5, 6, 13, 18, 25, 28	7	
RL	Амьдралд дургүйцэх	2, 9, 14, 15, 16, 21, 30	7	

AD	Үхэлд татагдах	8, 17, 19, 22, 23, 26, 27	7		
RD	Үхлээс зэвүүцэх	3, 4, 7, 10, 11, 12, 20, 24, 29	9		

Тайлбар: \_\_\_\_\_

#### 4. RES асуулга

Үр дүн

			Нийлбэр	Утга
Шууд	1, 3, 4, 7, 10	1=1, 2=2, 3=3, 4=4		
Урвуу үнэлэх	2, 5, 6, 8, 9	1=4, 2=3, 3=2, 4=1		

Жич: Доогуур оноо нь өөрийн үнэлгээ өндөр болохыг илэрхийлдэг.

## СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

### (Үйлчлүүлэгчийн хуудас)

Үйлчлүүлэгчийн код:

Үйлчлүүлэгчийн нас:

Үйлчлүүлэгчийн хүйс:

### 1. Нийлэмжийн сорил

Заавар:

Санаандаа орсон үгнүүдийг аль болох бодолгүй, түргэн нэрлэнэ үү. Яг одоо ил харагдаж байгаа зүйлс болон тоо биш байх, бичсэн үгээ тоолох шаардлагагүй. 60 болсон байх гэсэн үедээ зогсоорой. (Ойролцоогоор 50-60 үг бичнэ, эсвэл нэрлэнэ)

### 2. MAST аргачлал

Зөв, буруу хариулт гэж байхгүй бөгөөд та өөрийн мэдэрч, бодож буй зүйлдээ тулгуурлан хариулаарай. Таны өгөх хариулт бүр бидэнд чухал. Өгүүлбэр бүрийг анхааралтай уншиж, түүнийг ямар хэмжээнд зөвшөөрч байгаагаа тэмдэглээрэй.

- Хэрэв тухайн өгүүлбэр таны огт бодож байгаагүй эсвэл мэдэрч байгаагүй санааг тусгаж байвал “огт зөвшөөрөхгүй” гэсэн баганын доорх (1) гэсэн тоог дугуйлаарай;
- Тухайн өгүүлбэр таны ганц нэг удаа бодож, мэдэрч байсан санааг тусгаж байвал “зөвшөөрөхгүй” гэсэн баганын доорх (2) гэсэн тоог дугуйлна уу;
- Тухайн өгүүлбэр заримдаа бодож эсвэл мэдэрч байсан санааг тусгаж байвал “заримдаа зөвшөөрнө, заримдаа зөвшөөрөхгүй” гэсэн баганы доорх (3) гэсэн тоог дугуйлна;
- Тухайн өгүүлбэр олон удаа бодож, мэдэрч байсан санааг тусгавал “зөвшөөрнө” гэсэн баганы доорх (4) гэсэн тоог дугуйлаарай;
- Харин тухайн өгүүлбэрт таны үргэлж мэдэрч, бодож байдаг зүйл тусгагдсан байвал “бүрэн зөвшөөрнө” гэсэн баганын доорх (5) гэсэн тоог дугуйлна.

№	Асуумжууд	Огт зөвшөөрөхгүй	Зөвшөөрөхгүй	Заримдаа зөвшөөрнө, заримдаа зөвшөөрөхгүй	Зөвшөөрнө	Бүрэн зөвшөөрнө
1	Би ихэнхдээ аз жаргалтай мэдрэмжтэй байдаг.	1	2	3	4	5
2	Амьдрал урт удаан, хүнд хэцүү тэмцэл шиг санагддаг.	1	2	3	4	5
3	Үхлээс зайлахгүй гэсэн бодлоос би айдаг.	1	2	3	4	5
4	Миний оюун санааны бүхий л идэвх зогсонги байдалд орох учраас би үхлээс айдаг.	1	2	3	4	5
5	Заримдаа хүнд хэцүү үе тохиолддог ч амьдрал үнэ цэнтэй.	1	2	3	4	5

6	Ойр дотны хүмүүс надад санаа тавьж байгааг би мэдэрдэг.	1	2	3	4	5
7	Миний хувийн мөн чанар алга болох учраас би үхлээс айдаг.	1	2	3	4	5
8	Үхсэний дараа би өөд болсон хүмүүстэй дахин учирна гэдэгт итгэдэг.	1	2	3	4	5
9	Надад хэчнээн хэцүү хүнд байсан ч бусдаас тусламж хүсдэггүй.	1	2	3	4	5
10	Үхлийн тухай бодохоор жижүүдэс хүрдэг.	1	2	3	4	5
11	Миний бие ялзрах учраас үхлээс айдаг.	1	2	3	4	5
12	Ямар нэг зүйл хийх эсвэл ямар нэг зүйлийн тухай бодох чадвараа алдах учраас үхлээс айдаг.	1	2	3	4	5
13	Ирээдүйд би өндөр амжилтад хүрнэ гэдэгт итгэдэг.	1	2	3	4	5
14	Би өөрийгөө гэр бүлдээ чухал биш гэдгээ мэдэрдэг.	1	2	3	4	5
15	Намайг байгаагүй сэн бол манай гэр бүл илүү аз жаргалтай байх байсан юм шиг санагддаг.	1	2	3	4	5
16	Заримдаа миний асуудлууд шийдвэрлэгдэхгүй юм шиг санагддаг.	1	2	3	4	5
17	Үхэл асуудлыг сайн тал руу өөрчилж чадна.	1	2	3	4	5
18	Би олон зүйл хийх дуртай.	1	2	3	4	5
19	Үхэл мөн чанартаа мөнхийн амьдрал.	1	2	3	4	5
20	Нэгэн өдөр би айдсаас болж үхэх байх.	1	2	3	4	5
21	Би гэр бүлдээ цаг заваа зориулах дургүй.	1	2	3	4	5
22	Үхсэний дараа л олон асуудал шийдвэрлэгдэнэ.	1	2	3	4	5
23	Үхэл нь зовлон шаналлыг хөнгөлнө гэдэгт итгэдэг.	1	2	3	4	5
24	Миний төлөвлөгөө биелэгдэхгүй болох учраас үхлээс айдаг.	1	2	3	4	5
25	Би итгэл дүүрэн байдаг.	1	2	3	4	5
26	Зарим нөхцөлд амьдарснаас үхсэн нь дээр.	1	2	3	4	5
27	Үхэл амгалан байдал болон тайвшрал юм.	1	2	3	4	5
28	Би амьдралын олон зүйлд баярладаг.	1	2	3	4	5
29	Би үхлээс хамгийн их айдаг.	1	2	3	4	5
30	Хэн ч намайг үнэн санаанаасаа хайрладаггүй.	1	2	3	4	5

### 3. RES асуулга

Дараах хэмжүүрүүдээс өөрт тохирох хариултыг сонгоно уу. Үүнд: бүрэн зөвшөөрнө гэвэл 1 оноо, зөвшөөрнө гэвэл 2 оноо, зөвшөөрөхгүй гэвэл 3 оноо, огт зөвшөөрөхгүй гэвэл 4 оноогоор үнэлнэ үү.

1. Ерөнхийдөө би өөртөө сэтгэл хангалуун байдаг.
2. Заримдаа би өөрийгөө бүх талаараа сайн байж чаддаггүй гэж боддог.
3. Надад хэд хэдэн сайн чанар байдаг гэдгийг би мэддэг.
4. Бусад хүмүүстэй харьцуулахад би зарим зүйлийг илүү сайн хийдэг.



5. Надад бахархаад байх зүйл байдаггүй гэж боддог.
6. Заримдаа би өөрийгөө хэнд ч хэрэггүй гэж боддог.
7. Би өөрийгөө үнэ цэнтэй хүн гэдгээ мэдэрдэг.
8. Би илүү нэр хүндтэй байхыг хүсдэг.
9. Би өөрийгөө бүтэл муутай хүн гэж боддог.
10. Би өөртөө эерэг ханддаг.

## ЭРСДЭЛИЙН ЗЭРГИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Агуулга	Эрсдэл өндөр	Эрсдэл дунд зэрэг	Эрсдэл бага
<p><b>Илрэх шинжүүд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд аминд хүрэх нь тодорхой арга сонгосон (артерийн судас зүсэх, маш өндөр тунгаар эм уух гэх мэт),</li> <li>- Оролдлого хийсний дараа өөр хүн тусламж дуудсан байх</li> <li>- Хүнгүй үед оролдлого хийсэн байх</li> <li>- Гэрийнхэндээ болон найз нөхдөдөө салах ёс хийж байгаа мэт үйлдэл илэрхийлж байсан</li> <li>- Өөрийн хайртай эд зүйлийг бусдад бэлэглэх</li> <li>- Гэр бүлээс хэн нэг нь амиа хорлосон, эсвэл оролдлого хийж байсан эсэх.</li> <li>- Сэтгэл гутралын эсрэг эм хэрэглэж байсан эсэх</li> <li>- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж байсан</li> </ul> <p><b>Хүүхдийн өгүүлээр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үхэх тухай бодол удаан хугацааны турш байсан</li> <li>- Өмнө бас ийм бодол хүчтэй төрдөг байсан</li> <li>- Төлөвлөгөө гаргасан</li> <li>- Үхэх тухай судалсан</li> <li>- Тэмдэглэл хөтөлж байсан</li> <li>- Аргаа сонгосон</li> <li>- Хэрэгслээ бэлдсэн</li> <li>- Хугацаа товловсон</li> </ul>	<p><b>Асран хамгаалагчаас:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд аминд хүрэх нь тодорхой арга сонгосон (артерийн судас зүсэх, маш өндөр тунгаар эм уух гэх мэт),</li> <li>- Оролдлого хийсний дараа өөр хүн тусламж дуудсан байх</li> <li>- Хүнгүй үед оролдлого хийсэн байх</li> <li>- Гэрийнхэндээ болон найз нөхдөдөө салах ёс хийж байгаа мэт үйлдэл илэрхийлж байсан</li> <li>- Өөрийн хайртай эд зүйлийг бусдад бэлэглэх</li> <li>- Гэр бүлээс хэн нэг нь амиа хорлосон, эсвэл оролдлого хийж байсан эсэх.</li> <li>- Сэтгэл гутралын эсрэг эм хэрэглэж байсан эсэх</li> <li>- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж байсан</li> </ul> <p><b>Хүүхдийн өгүүлээр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үхэх тухай бодол удаан хугацааны турш байсан</li> <li>- Өмнө бас ийм бодол хүчтэй төрдөг байсан</li> <li>- Төлөвлөгөө гаргасан</li> <li>- Үхэх тухай судалсан</li> <li>- Тэмдэглэл хөтөлж байсан</li> <li>- Аргаа сонгосон</li> <li>- Хэрэгслээ бэлдсэн</li> <li>- Хугацаа товловсон</li> </ul>	<p><b>Асран хамгаалагчаас:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд амиа хорлох үйлдэл хийсэн боловч аминд хүрэх нь бага байж болно</li> <li>- Оролдлого хийсний дараа өөрөө тусламж дуудсан байх</li> <li>- Хүний хажууд оролдлого хийсэн байх</li> <li>- Гэрийнхэндээ болон найз нөхдөдөө салах ёс хийж байгаа мэт үйлдэл илэрхийлж байсан</li> <li>- Сэтгэцийн эмчид өмнө хандаж байгаагүй</li> </ul> <p><b>Хүүхдийн өгүүлээр:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үхэх тухай бодол хааяа төрж байсан</li> <li>- Төлөвлөгөө байхгүй</li> <li>- Үхэх тухай судалж байгаагүй</li> <li>- Аргаа сонгоогүй</li> <li>- Хугацаа товлоогүй</li> </ul> <p><b>Ажиллалтаар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн харц хурц, үзэн ядсан гэх мэт мэдрэмж туссан байх</li> <li>- Нойрны илтгэл хямрал ажиглагдахгүй байх</li> <li>- Болгоомжилсон</li> <li>- Сэтгэлээр унасан</li> <li>- Түгшсэн</li> <li>- Идэвх, эрч хүч харилцан адилгүй шинжтэй байх</li> <li>- Гарын шунд олон жижиг зүслэгтэй байж болно</li> <li>- Өөрийгөө хянах чадвартай байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Оролдлого бараг хийж байгаагүй</li> <li>- Үхэх тухай бодол бага төрж байсан</li> <li>- Хүүхэд болгоомжтой байх</li> <li>- Сэтгэл түгшилттэй байх</li> <li>- Амьдралын ямар нэг зорилготой байх, тухайлбал бие даалгаа хийх, дүүгээ авах гэх мэт</li> <li>- Идэвх багасаад 14-21 хоногоос хэтрээгүй байх</li> <li>- Нойрны хямрал бага байх</li> <li>- Сэтгэл хөдөлгөх зүйлтэй байх</li> </ul>

Агуулга	Эрсдэл өндөр	Эрсдэл дунд зэрэг	Эрсдэл бага
	<p><b>Ахиглалтаар:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн харц хөдөлгөөн багатай</li> <li>- Унтаагүйгээс улайсан байх</li> <li>- Шийдэмгий төрх</li> <li>- Идэвх, эрч хүч бага</li> <li>- Хэт тайван амгалан байдал</li> <li>- Гарын шуунд олон жижиг гэхээсээ гүнзгий, аминд ойр газар зүслэгтэй байх</li> <li>- Хүйтэн, мөнх бусын, бурхны гэх мэт шивээстэй байх</li> <li>- Гарын сарвууны хэсэгт эвэршсэн эсэх</li> <li>- Өөрийгөө хянах чадвартай байгаа эсэх</li> </ul>		
Нийлэмжийн сорилд:	Идэвх суларсан, амьдрал угга учиргүй болсон, хөвөх нисэх мэт мэдрэмж төрсөн, хийсвэр агуулгатай, сөрөг сэтгэл хөдлөл, шаналал зэрэг үгс	Идэвх суларсан, амьдрал угга учиргүй болсон, сөрөг сэтгэл хөдлөл бүхий, хийсвэр агуулгатай үгс байж болох ч үйл үг, зорилго, зэрэг сэтгэл хөдлөл хөндсөн үгс илэрч болно	Бодит агуулгатай, санаа зовнисон, залуу хүрсэн, гомдсон, уур хүрсэн, идэвхтэй, үйл үг, тэмдэг нэр гэх мэт нийлэмж
Түргэвчилсэн сорилд:	Аль нэг асуултад тийм гэж хариулах	Аль нэг асуултад тийм гэж хариулах	Тийм гэсэн хариулт байхгүй байх
MAST	Үхэлд татагдах болон амьдралд дургүйцэх үзүүлэлт өндөр байх	Амьдралд татагдах болон үхлээс зэвүүцэх үзүүлэлт нь хол зөрүүгүй байх	Үхлээс зэвүүцэх хандлага давуу байх Амьдралд татагдах үзүүлэлт дургүйцэх үзүүлэлтээс өндөр болон чацуу байх
RES	Өөрийн үнэлгээ доошилсон, төстээр оноо өндөр байх	Өөрийн үнэлгээ доошилсон, дунд зэрэг, төстээр оноо өндөр байх	Өөрийн үнэлгээ өндөр, дундаж үзүүлэлт байж болно
Анхаарах зүйл	<ul style="list-style-type: none"> <li>- Тусламж ирэх хүртэл хүнтэй цуг байлгах</li> <li>- Хор хөнөөл учруулж болох зүйлийг холдуулах</li> <li>- Түүнийг сонсох хэрэгтэй, шүүмжлэхгүй, буруутгахгүй, хөнддүр сэдвээр удаан хугацааны турш ярьж эмзэглүүлэхгүй байх</li> </ul>	Эцэг эх, асран хамгаалагчид сэтгэцийн эмч, сэтгэл засалчид заавал хандах ёстой талаар мэдээлж, гарын үсэг зуруулна. Танин мэдэхүй зан үйлийн засалд үргэлжлүүлэн хамруулна.	Өсвөр насны хүүхдийн сэтгэл тугшилтийг бууруулах хөтөлбөрийн дагуу ажиллана. Эцэг эх, асран хамгаалагчид хэрхэн харилцах талаар зөвлөмж өгнө.

Агуулга	Эрсдэл өндөр	Эрсдэл дунд зэрэг	Эрсдэл бага
Хөтлөх удирдамж	Амиа хорлох эрсдэл өндөр гэж үйлчлүүлэгчийг үнэлсэн тохиолдолд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн нарийн мэргэжлийн байгууллагад холбон зуучилж сэтгэцийн эмчид үзүүлэх, тодорхой хугацаанд сэтгэл засалд хамруулах нь ёстой.	Амиа хорлох эрсдэл дунд гэж үнэлсэн тохиолдолд сэтгэл түгшилт, сэтгэл гутралын шинжүүдийг багасгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.	Амиа хорлох эрсдэл бага гэж үнэлсэн тохиолдолд сэтгэл түгшилтийг багасгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.
Үйлчлүүлэгчийн эрсдэлийн төвшин (харгалзах нүдэнд «✓» тэмдэглэх)			

## АСРАН ХАМГААЛАГЧААС ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТАЛААР ТАНИУЛСАН ЗӨВШӨӨРӨЛ

**Сэтгэл зүйн зөвлөгөөний онцлог:** Үйлчлүүлэгчид тулгарсан асуудлаас үүдэлтэй сөрөг зан үйл, сөрөг бодлуудыг эергээр өөрчлөхөд туслах, нөхцөл байдлыг бодитойгоор хүлээн авч, үйлчлүүлэгч түүнийг даван туулахад сэтгэл зүйч хамтран ажиллана.

- Асуудал, бэрхшээлийг мэргэжлийн түвшинд тодорхой үе шаттайгаар явуулж, цаашид авч болох арга замуудыг хамтдаа шийднэ.
- Шаардлагатай тохиолдолд сэтгэцийн эмч, сэтгэл засалчид хандах талаар санал болгож болно.
- Үйлчлүүлэгч сэтгэл судлаачтай хамтран ажиллаж, асуудлаа тодорхойлж, гарцаа хайх, шийдвэрлэх эрхтэй бөгөөд сэтгэл зүйн зөвлөгөөг авахаас татгалзах эрхтэй.

**Нууцлал:** Сэтгэл зүйч үйлчлүүлэгчийн өгсөн мэдээллийг мэргэжлийн ёс зүйн хүрээнд чандлан нууцлах үүргийг хүлээнэ.

**Сэтгэл зүйн зөвлөгөөний зорилго:** Хүүхдэд тулгамдсан асуудал, гэр бүлийн болон бусад орчны харилцаанд үүсэж буй асуудал, насны онцлогоос шалтгаалсан сэтгэл зүйн асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

**Сэтгэл зүйн зөвлөгөөний явц:**

**Нэг.** Эрсдэлийн үнэлгээ хийх уулзалт

**Хоёр.** Мэдрэмж гадагшлуулах уулзалт

**Гурав.** Сэтгэл зүйн нөөцийг нэмэгдүүлэх уулзалт

**Дөрөв.** Цаашдын төлөвлөгөө гаргах уулзалт гэсэн 4 үе шаттайгаар явагдана.

**Үргэлжлэх хугацаа:** Тухайн үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлаас хамааран сэтгэл зүйн зөвлөгөөний уулзалтын тоо 4 болон түүнээс дээш удаа явагдана. Нэг удаагийн уулзалт 60 хүртэл минут үргэлжилнэ.

### Зөвшөөрлийн маягт

Миний бие ..... овогтой ..... сэтгэл зүйн зөвлөгөөний тухай мэдээлэлтэй танилцсан. Тиймээс өөрийн хүү / охин / асран хамгаалж буй хүүхэд болох ..... -г сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдахыг зөвшөөрч байна.

Гарын үсэг ..... Огноо .....

## ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ТУХАЙ ХУУДАС

Хүүхдийн сэтгэл зүйн байдлын талаар мэдээлэл

Огноо: \_\_\_\_\_

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_, \_\_\_\_\_ настай \_\_\_\_\_, эрэгтэй, эмэгтэй (зурах)

Хүүхэд амиа хорлох бодол санаа төрсөн, оролдлого хийсэн (зурах) бөгөөд сэтгэцийн эмч, сэтгэл засалчид хандах нь зүйтэй.

Хүүхдийн сэтгэл зүйн үнэлгээ:

	Сэтгэл зүйн аргачлалын нэр	Оноо	Тайлбар
1			
2			
3			
4			
5			

Танилцсан:

Эцэг эх, асран хамгаалагчийн нэр: ..... Утасны дугаар: .....

Мэдээлэл өгсөн:

Сэтгэл зүйч ..... Тэмдэг

## ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хүүхэд амиа хорлох бодол санаа төрсөн байх, эсвэл оролдлого хийсэн байх вий гэж анзаарсан бол дараах шинжүүдийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Өсвөр насны хүүхэд түрэмгий зантай байх
- Үг яриа цөөрөх, дотогшоо болох
- Хоолны дуршил багасах, үгүй болох
- Өөрийгөө гэмтээх, өвтгөхийг хүсэх
- Идэвхгүй, хайхрамжгүй хандлагатай болох
- Сэтгэл гутралд орсон, үхлийн тухай агуулга бүхий үйл явдал, ном, кино, бичлэг, мэдээ зэрэгт анхаарах нь ихсэх, ярих, судлах
- Үхэх тухай шууд болон дам байдлаар мэдээлэл өгөх
- Сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх

Хэрэв асуудал хэт төвөгтэй, гэр бүлийн болон найз нөхдийн дэмжлэг дутмаг, хүүхэд даван туулах чадвар сул, өөр гарц гаргалгаа олж чадахгүй байгаа бол эмнэлгийн тусламж зайлшгүй шаардлагатай.

Хүүхэд амиа хорлох бодол санаа төрсөн байх, эсвэл оролдлого хийсний дараа анхаарах зүйл:

- Хөтөлбөрийн дагуу эрсдэлийн үнэлгээгээр амиа хорлох эрсдэл өндөр болон дунд зэрэг гэж үнэлсэн үед сэтгэцийн эмнэлэгт хандах, эмчилгээ, сэтгэл засал хийлгэх
- Эрсдэл бага гэж үнэлсэн тохиолдолд сэтгэл түгшилтийг бууруулах чиглэлээр сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд үргэлжлүүлэн хамруулах
- Амиа хорлох оролдлогоос хойш гурван сарын хугацаанд ихэнх хүүхэд хэвийн байдалдаа орж сэтгэл зүйн тогтвортой болдог тул энэ хугацаанд маш анхааралтай байх, ярилцаж ойлгох, ойр дотно байх, халамжлах
- Хүүхдийн дэргэд эргэн тойрны хүмүүс нь амиа хорлох тухай ярихгүй байх, сургуулийн орчинд мөн энэ талаар ярихгүй байх талаар багш болон ангийнханд анхааруулж холбоотой байх
- Хүүхдээс үхэх тухай бодоод байгаа эсэхийг шууд асууж болно. Яаж, хэзээ, хаана зэргээр тодорхой болгоход нөлөөлөх асуулууд тавихгүй
- Хүүхэдтэй харилцахдаа болон гэр бүлийн гишүүд хоорондын харилцаандаа хэт их зовж шаналсан, шантарсан царай харуулахгүй байх
- Өөрийг нь ойлгож, өөрийнх нь талд байгаа гэдгийг мэдрүүлэх
- Хүүхэдтэй ярихдаа хоолойны өнгийг тайван байлгаж, намуухан дуугаар ярих
- Хүүхдийг буруутгалгүй, байнга үглэхгүй, харилцан ярилцаж санал бодлыг нь сонсож таагүй мэдрэмжээ гадагшлуулахад тусална. Ойлгож сонсоно гэдэг мэдрэмжийг гадагшлуулахад тусалж байна гэсэн үг юм.
- Амиа хорлоход хүргэж болзошгүй эд зүйл, эм, бодис хадгалж, цуглуулж байгаа эсэхийг анзаарч байх

## ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДТЭЙ ХАРИЛЦАХДАА ХЭРЭГЛЭЖ БОЛОХ ҮГС

Энэхүү хэсгийг “Өсвөр үеийнхэнд өгөх сэтгэл зүйн зөвлөгөө” номоос дэлгэрүүлэн уншина уу.

- Чи одоо том болсон учраас хоёулаа болсон үйл явдлын талаар нухацтай ярилцъя.
- Би чамтай энэ талаар зөвлөхийг хүсэж байна.
- ..... чамд ямар санагдаж байна?
- Хоёулаа ..... гэж тохирох уу?
- ..... талаар хоёулаа .....ингэж шийдэх үү?
- .....талаар чиний санал их чухал байна.
- ..... гэж бид тохирлоо гэж үзэх үү?
- Чамайг чадна гэж би бодож байна.
- ..... юманд энэ талаас хандана гэдэг нь чамайг нухацтай болохыг харуулж байна.
- Чамайг жаахан хүүхэд шиг хэлснээсээ буцахгүй гэж бодож байна.
- Би чамайг ингэж хэлнэ гэж найдаж байсан юм, баярлалаа.



## ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ ХУУДАС

(Санал болгох загвар)

	Өдөрт тогтмол хийх (Заавал тусгах агуулга)	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
	<b>ТОГТМОЛ ХИЙХ АЖИЛ</b>							
1	Өдөрт 30 минут алхах, салхинд гарах, хөдөлгөөн хийх							
2	Хүнтэй ярилцах, доод тал нь 5 минут							
3	Сэтгэл хангалуун болгодог зүйлс өдөрт 2 -ыг бичих							
	<b>СОНИРХЛООР ХИЙЖ БОЛОХ АЖИЛ</b>							

Би .... сарын .... хүртэл дараах зүйлүүдийг хийж чадна.

\_\_\_\_\_ гарын үсэг

## ХӨТӨЛБӨРИЙГ ДАГАЛДАХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

Арга, техник	Хэрэглэгдэхүүн	Хөтөлбөрийн аль үед ашиглагдах
Хамгаалах байран дахь нэгдсэн багц хэрэглэгдэхүүн		
Хөгжим заслын хэрэглэгдэхүүн	Спикер	НЭГ. Эрсдэлийн үнэлгээ хийх уулзалт ХОЁР. Мэдрэмж гадагшлуулах уулзалт ГУРАВ. Сэтгэл зүйн нөөцийг нэмэгдүүлэх уулзалт
	Memory card	
	Чихэвч	
Метафор картууд	Банхар карт Ий күү карт Шүхэр карт	НЭГ. Эрсдэлийн үнэлгээ хийх уулзалт ХОЁР. Мэдрэмж гадагшлуулах уулзалт
Булчингийн нөлөөллөөр тайвшруулах хэрэглэгдэхүүн	Иогийн гудас	Хөтөлбөрийн бүхий л хэсэгт үйлчлүүлэгчид нээлттэй байдлаар санал болгоно.
Өсвөр насны (11-16 нас) хүүхдэд зориулсан багц хэрэглэгдэхүүн		
Тайвшруулах зурах, будах хэрэглэгдэхүүн	Буддаг мандала ном	Хөтөлбөрт заасан арга техник үйлчлүүлэгчид тохиромжгүй байх тохиолдолд нээлттэй байдлаар санал болгоно.
	Тэмдэглэлийн дэвтэр	
	Нарийн фламастр	
Булчингийн нөлөөллөөр тайвшруулах хэрэглэгдэхүүн	Массажны хэрэгсэл	Хөтөлбөрийн бүхий л хэсэгт үйлчлүүлэгчид нээлттэй байдлаар санал болгоно.
	Базах, атгах бөмбөг	

## НОМ ЗҮЙ

---

1. Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үзүүлэх заавар батлах тухай. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 18-ны А149 тоот тушаал.
2. Монгол Улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдол. УБ.,2016
3. ЭМХТ, ДЭМБ. Эрүүл мэндийн үзүүлэлт, 2019.  
[http://hdc.gov.mn/media/uploads/2020-08/2019-eruul\\_mendin\\_uzuulelt\\_MU\\_mail.indd\\_2020\\_\\_\\_\\_7\\_\\_21final.pdf](http://hdc.gov.mn/media/uploads/2020-08/2019-eruul_mendin_uzuulelt_MU_mail.indd_2020____7__21final.pdf)
4. ЭМЯ, СЭМҮТ, АШУУИС, USAID, WHO, UNICEF. Амиа хорлох төрх үйлээс урьдчилан сэргийлэх нь. УБ.,2020
5. ЭМЯ, СЭМҮТ, USAID, WHO, UNICEF. Өсвөр үеийнхэнд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. УБ.,2020
6. НЭМГ, UNICEF. Өсвөр үеийнхэнд өгөх сэтгэл зүйн зөвлөгөө. УБ.,2014
7. ХНХЯ, Uniterra. Сэтгэл зүйн хурц гэмтлийн үеийн хямралыг даван туулахад баримтлах гарын авлага. УБ.,2017
8. Orbach, I., Milstein, I., Har-Even, D., Apter, A., Tiano, S., & Elizur, A. (1981). A Multi-Attitude Suicide Tendency Scale For adolescents. Psychological Assessment
9. Rosenberg, M. (1979). Conceiving the Self. New York: Basic books.
10. David B. Goldston. Assessment of Suicidal Behaviors and Risk Among Children and Adolescents. Wake Forest University School of Medic. 2000

